



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

2024

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



- 4 Ерөнхий мэдээлэл
- 6 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- 8 Тогтвортой байдлын онцлох мэдээллүүд
- 10 Хүлэмжийн хийн ялгарал

ЗАСАГЛАЛ



- 13 Тогтвортой байдлын он цагийн товчоо
- 14 Стратеги
- 15 Бүтэц, зохион байгуулалт, хяналт
- 16 ТУЗ-ийн түвшинд
- 16 ТУЗ-ийн гишүүдийн туршлага болон мэргэшил
- 18 Удирдлагын багийн оролцоо ба дэмжих засаглал
- 20 2030 болон 2050 оны зорилго, зорилтууд

ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ



- 22 Тогтвортой, ногоон санхүүжилт
- 22 Тогтвортой, ногоон зээлийн багц
- 27 Ногоон бизнесийн шилжилтийг санхүүжүүлэх нь
- 28 Иргэдийн ногоон хэрэглээг санхүүжүүлэх нь
- 29 Бидний үзүүлж буй нөлөө
- 30 Санхүүжүүлсэн болон хөрөнгө оруулсан хүлэмжийн хийн ялгарал
- 34 ХХЯ өндөр салбарууд ба бууруулах нарийвчилсан төлөвлөгөө

ТОГТВОРТОЙ, НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА



- 38 Үйл ажиллагаанаас үүдэн ялгарч буй хүлэмжийн хийн ялгарал
- 41 Тогтвортой, ногоон үйл ажиллагаа
- 44 • Эрчим хүч
- 44 • Ус
- 45 • Хог хаягдал

НИЙГЭМ



- 48 Нийгмийн хариуцлага
- 51 Төсөл хөтөлбөр, аян
- 53 Оюутнуудыг дэмжих хөтөлбөр
- 54 Хүний нөөц-Үл ялгаварлах, тэгш эрх, оролцоо
- 55 НҮББОХ-ХБЗ 2030 он хүртэлх хамрах хүрээ
- 56 Хүний эрхийг хүндэтгэн дээдлэх
- 57 Ажилтнуудын хангамж
- 58 Бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөл
- 59 Жижиг дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадавхыг бэхжүүлэх



ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО



- 62 Мэдлэгээ хуваалцах, бусдыгаа манлайлах нь
- 64 Оролцогч талуудын хамтын ажиллагаа
- 65 Гишүүнчлэл

БОНЗ ТАЙЛАГНАЛЫН ОУ-ЫН СТАНДАРТУУДЫН НИЙЦЭЛ



- 94 НҮББОХ-Банк Санхүүгийн Санаачилга, Хариуцлагатай банкны зарчмуудын хэрэгжилтийн тайлан
- 100 2023 оны хүлэмжийн хийн тооцооллын тодруулга

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ



- 68 Засаглал
- 70 Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжууд
- 77 Харилцагчдын байгаль орчин нийгмийн эрсдэлийг удирдах нь

ТООН ТОДРУУЛГА



- 80 Ажилтнуудын тоон мэдээлэл
- 82 Байгаль орчинтой холбоотой тоон мэдээлэл
- 84 Хүлэмжийн хийн ялгаруулалт
- 86 Бусад мэдээлэл
- 90 БОНЗ-той холбоотой шагнал
- 91 Ил тод нээлттэй тайлагнал



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тайлан бэлтгэсэнтэй холбоотой мэдэгдэл

Голомт банк ХК-ийн 2024 оны Тогтвортой хөгжлийн тайлан (цаашид "Тайлан" гэх) нь Голомт банк ХК (цаашид "Голомт банк", "банк" эсвэл "бид" гэх)-ийн Байгаль орчин, Нийгэм, Засаглал (цаашид БОНЗ гэх) болон ногоон санхүүжилтийн чиглэлээр 2024 онд хийгдсэн үйл явц, ахиц дэвшлийн талаар мэдээлэл өгөх зорилготой юм. Үүнд банкны ногоон болон нүүрстөрөгч багатай санаачилгуудыг дэмжсэн болон ногоон санхүүжилтийг уриалсан ололт амжилтуудыг багтаасан болно. Өөрөөр заагаагүй бол, энэхүү тайлан нь 2024 оны 1-р сарын 1-ээс 12-р сарын 31-нийг хүртэлх санхүүгийн жилийн мэдээллийг агуулна.

Тайлангийн тухай

Энэхүү Тогтвортой хөгжлийн тайлан нь Гүйцэтгэх захирлаар баталгаажсан ба дараах хууль дүрэм, стандарт, удирдамжийн дагуу бэлтгэгдсэн болно.

Монголын хөрөнгийн бирж- БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж (2022 онд гарсан)

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Санхүүгийн санаачилга- Хариуцлагатай банкны зарчмууд, (2019 онд гарсан)

Монгол улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмууд (2015 онд гарсан)

Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөл/ISSB-ийн Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсгийн (TCFD) зөвлөмжүүд (2023 онд гарсан)

Өгөгдлийн мэдэгдэл

Тайлан дах тоо баримтууд нь 2024 оны 1-р сарын 1-ээс 2024 оны 12-р сарын 31-ний хооронд байна. Өөрөөр заагаагүй бол, тайланд дурдсан мөнгөн дүн төгрөгөөр илэрхийлэгдсэн болно. 2024 оны Хариуцлагатай банкны зарчмын тайлангийн мэдээлэлд Дотоод Аудитын Газраас баталгаажуулалт хийсэн болно.

Нийтлэлийн хэлбэр

Тайланг онлайн хэлбэрээр гаргасан ба банкны вэбсайтаас татан авах боломжтой. Тайлан нь англи, монгол хэл дээр гарсан бөгөөд хоёр хувилбарын хооронд зөрүү гарсан тохиолдолд монгол хувилбарыг баримтална.

Холбоо барих: sfd@golomtbank.com

“Хариуцлагатай банкны зарчмын тайлан” баталгаажуулалтын хураангуй үр дүн**Хамрах хүрээ:**

Голомт банкны Дотоод аудитын газар нь банк НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн “Хариуцлагатай банкны зарчим”-д нэгдсэн банкуудын “Хариуцлагатай банкны зарчмын тайлан” бэлдэх удирдамжийн дагуу боловсруулж, “Тогтвортой хөгжлийн тайлан-2024”-т тусгасан дараах 6 зарчмын хэрэгжилтийг нотлох мэдээлэл, тооцоолол, үр дүнд 2024.12.31-ний өдрийн байдлаар баталгаажуулалт хийсэн.

1. Нийцэл (Alignment)
2. Нөлөөлөл ба зорилгод түвшин (Impact & Target setting)
3. Хариуцагч, үйлчлүүлэгчид (Clients & Customers)
4. Оролцогч талууд (Stakeholders)
5. Засаглал ба соёл (Governance & Culture)
6. Ил тод байдал ба хариуцлага (Transparency & Accountability)

Хараат бүс байдал:

Дотоод Аудитын Газар нь Голомт банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлд харьяалагдах зохион байгуулалтын бүтцийн нэгж бөгөөд Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг. Голомт банкны Дотоод Аудитын үйл ажиллагаа нь 2021 онд хондлогийн байгууллагаар чанарын баталгаажуулалт хийлгэж, “Дотоод Аудитын Олон Улсын Стандарттай 100% нийцсэн, Аудиторууд нь Аудиторын Ёс зүйн кодыг мөрдөж ажилладаг” гэх дүгнэлт авсан Монгол Улсын анхны Дотоод Аудитын нэгж юм.

Арга зүй:

- Тайланд тусгагдсан мэдээлэл, хийгдсэн ажлууд нь бодитой эсэхийг баталгаажуулах зорилгоор холбогдох тушаал, шийдвэр, зохицуулалтын баримт бичиг зэрэг нотлох баримтуудыг цуглуулж, хариуцсан ажилтнуудаас тодруулга авч тулган баталгаажуулсан.
- Тайланд тусгагдсан тоо мэдээлэл, тооцоололд ашигласан өгөгдлийн чанарыг баталгаажуулах зорилгоор өгөгдлийн эх үүсвэрийг тодорхойлж, өгөгдлийн сан, өгөгдөл боловсруулсан нэгжүүдээс мэдээлэл цуглуулж, тулган баталгаажуулсан.
- Тооцоолол хийхдээ ашигласан өгөгдлийг боловсруулж, мэдээллийг ангилахдаа холбогдох аргачлалын дагуу зөв хийсэн эсэхийг түүврээр баталгаажуулсан.
- Тайланд тусгагдсан тооцоолол нь холбогдох аргачлалын дагуу зөв хийгдсэн эсэхийг баталгаажуулсан.

Дүгнэлт:

“Хариуцлагатай банкны зарчмын тайлан”-д хийсэн баталгаажуулалтаар тус 6 зарчмын хүрээнд хийгдсэн ажил, тооцоолол нь бодит байдлаас зөрүүтэй тусгагдсан эсвэл материаллаг хэмжээний өөрчлөлт, сайжруулалт хийхүйц асуудал илрээгүй. Харин баталгаажуулалтын явцад сайжруулах шаардлагатай асуудлууд гарсныг тухай бүр явцын үүрэг өгч засварлуулсан. Мөн тооцоололд ашиглагдах өгөгдлийн чанар, хамрах хүрээг нэмэгдүүлэх, автоматжуулах боломжийг судалж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлд холбогдох зөвлөмжүүдийг хүргүүлэв.

Тайланг хэрэглэх хязгаарлалт:

Энэхүү тайлан нь зөвхөн Голомт банкны мэдээлэл, тайланд ашиглагдах зориулалттай тул хэвлэх, хувилах, гадагш задруулах нь хоригтой. Тайлан, хавсралтуудыг банкны дотоод болон гуравдагч этгээдэд өгөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд Аудит хариуцсан захирал эсвэл Дотоод Аудитын Газрын захиралд хандана уу.

Аудит хариуцсан захирал эсвэл Дотоод Аудитын Газрын захирлаас тайлан, хавсралтуудтай танилцах зөвшөөрөл авсан банкны дотоод болон гуравдагч этгээд нь дээр дурдсан үүргийг мөн хүлээнэ.

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ:

А.ТУЯА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



А.ОДОНБААТАР
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Голомт банк нь дэлхий дахинд тулгамдсан асуудал болоод байгаа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой сорилтуудыг сааруулах, дасан зохицох, Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахад хүлээсэн чухал үүргээ ухамсарлаж, өөрсдийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ дамжуулан ногоон эдийн засгийн шилжилтийг хурдасгахад бодитой хувь нэмрийг оруулсаар байна.

Түүнчлэн бид стратеги, зорилго, зорилтуудаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцүүлэн, нөөцийг үр ашигтайгаар хуваарилж, эерэг өөрчлөлтийн хил хязгаарыг тэлж, шинэ боломжуудыг бий болгохыг эрэлхийлж байна.

Байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах, сайн засаглалыг бэхжүүлэхийн зэрэгцээ сайн сайхныг санхүүжүүлдэг хариуцлагатай банк байх нь бидний зорилго билээ.

Сүүлийн жилүүдэд цаг уур, байгалийн гамшигт үйл явдлууд улам хурцдаж, давтамж нь нэмэгдсээр байна. 2024 онд Монгол улсад сүүлийн 50 жилд тохиолдоогүй хамгийн

хүнд зуд боллоо. Хүн амын гуравны нэг нь нүүдэллэн амьдардаг, мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай манай улсад ийм зуд тохиох нь нийгэм, эдийн засгийн хувьд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй энэ мэт байгалийн гамшигт үзэгдлүүд нь эдийн засаг болон бизнесийн тогтвортой байдалд хүндээр нөлөөлөхүйц эрсдэл болоод байгаа нь бид бүгдийн оролцоо, хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Голомт банк ч мөн өөрийн оролцоог тодорхойлж, үйл ажиллагаа болон санхүүжилтээрээ дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг 2023 онд Хамрах хүрээ 1,2 болон 3-ийн хүрээнд тооцоолон, цаашид бууруулах дунд болон урт хугацааны зорилтуудыг тавин ажиллаж байна.

Энэхүү зорилтдоо хүрэхийн тулд өнгөрсөн онд шинжлэх ухааны үндэслэлтэй, мөн үндэсний онцлогт тохирох арга барилаар тогтмол сайжрах алхмуудыг хийв. Тайлант он болон ирэх онуудад бид нүүрстөрөгчийн хийн ялгарал хамгийн өндөр 7 салбаруудын онцлогт тохирсон шилжилтийн төлөвлөгөөнүүдийг үе шаттайгаар гарган, өөрийн үйл ажиллагаа болон санхүүжилтээрээ дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг

бууруулах зорилго зорилтдоо хүрэхээр үргэлжлүүлэн ажиллах болно.

Голомт банкны хувьд санхүүжилтээрээ дамжуулан харилцагчдынхаа ногоон шилжилтийг дэмжих, тогтвортой ногоон санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувийг тогтвортой, ногоон санхүүжилтээр бүрдүүлэх зорилт тавьсан. Энэхүү зорилтын хүрээнд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 875 тэрбум төгрөгийн ногоон санхүүжилтийг олгосон ба, үүнээс 309 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2024 онд олгосон байна.

Өнгөрсөн онд тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилтийн хүрээнд гаргасан ахиц дэвшил нь банкны нийт удирдлага болон ажилтнуудын маань хичээл зүтгэл, шаргуу хөдөлмөрийн үр дүн билээ.

Банкны тогтвортой байдлыг бэхжүүлэх, бодит эерэг нөлөөллийг бий болгоход хамтран ажиллаж буй эрхэм харилцагчид, зохицуулагчид, олон улсын хөгжлийн байгууллагууд болон бусад оролцогч талууддаа талархал илэрхийлье!

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

875 ТЭРБУМ ТӨГРӨГ



2019 оны 3-р улирлаас 2024 оны 4-р улирлын хооронд 875 (2023: 565) тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгосон бөгөөд үүнээс 309 (2023: 243) тэрбум төгрөгийг 2024 онд олгосон байна.

2030: 30% ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ
2030: 30% (суурь өгөгдөл 2023)
2050: 50% 2050: 50% (суурь өгөгдөл 2023)

265 ТЭРБУМ ТӨГРӨГ



Ногоон зээлийн багц 265 (2023:183) тэрбум төгрөг болсон байна. Энэ нь:

Банкны нийт зээлийн багцын 3.6%

Зах зээлийн 19.6% хувийг эзэлж байна

2030: 5% УСНЫ НӨӨЦ
2030: 5% (суурь өгөгдөл 2023)
2050: 10% 2050: 10% (суурь өгөгдөл 2023)

ЭРЧИМ ХҮЧ 30%



2030 он гэхэд Эрчим хүчний хэрэглээг 30% бууруулах (2023 суурь үзүүлэлтээс)

УСНЫ ХЭРЭГЛЭЭ 5%



2030 он гэхэд Усны хэрэглээг 5% бууруулах (2023 суурь үзүүлэлтээс)

ДАХИВАР ХОГ ХАЯГДАЛ 30%



2030 он гэхэд Дахивар хог хаягдлын хэмжээг 30% нэмэх (2023 суурь үзүүлэлтээс)

ХУДАЛДАН АВАЛТ 50% НОГООН



Тогтвортой, ногоон худалдан авалтын стандартыг батлан 2030 он гэхэд нийт худалдан авалтын 50%-ийг ОУ-ын шаардлагатай нийцүүлж тогтвортой, ногоон худалдан авалтаар бүрдүүлэх зорилт тавив.



ТОС ОНЦЛОХ БАНК
2024



ТЭРБУМ МОД САНГИЙН
ШИЛДЭГ ДЭМЖИГЧ 2024



TOP-THIRD
S&P БОНЗ ҮНЭЛГЭЭ

2024

103 МЯНГАН

тнCO₂e



Өөрийн үйл ажиллагаанаас ялгарч буй хүлэмжийн хийн хэмжээг бууруулсаар байна

2023 оны өөрийн үйл ажиллагаанаас

1.7 САЯ

тнCO₂e



САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛСАН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ

2024 оны нийт санхүүжүүлсэн ХХЯ

2023

235 МЯНГАН

тнCO₂e¹



Өөрийн үйл ажиллагаанаас ялгарч буй хүлэмжийн хийн хэмжээг бууруулсаар байна.

2024 оны өөрийн үйл ажиллагаанаас

1.03 САЯ

тнCO₂e²




САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛСАН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ

2023 оны нийт санхүүжүүлсэн ХХЯ /суурь он/

50САЯ

АМ.ДОЛЛАРЫН

НОГООН, НИЙГМИЙН БОНД
ГАРГАЛАА



LEED O+M

GOLD СЕРТИФИКАТ

Төв оффисын барилга LEED O+M
GOLD сертификат авав.



¹ 2023 оны хүлэмжийн хийн тооцооллыг сайжруулж залруулсан болно. Хавсралт хэсгээс дэлгэрэнгүй тайлбар харна уу.

² 2023 оны хүлэмжийн хийн тооцооллыг сайжруулж залруулсан болно. Хавсралт хэсгээс дэлгэрэнгүй тайлбар харна уу.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Хамрах хүрээ1 (тнCO2e)



Түлш:

2024: 96,130.59

2023: 231,794.22



Агааржуулагч:

2024: 34.07

Хөргөгч, хөргүүр:

2024: 0.41

Хамрах хүрээ3 бусад (тнCO2e)



Хог хаягдал:

2024: 2,050.77

2023: 2,175.73



Томилолт:

2024: 166.24

2023: 145.44



Ажилтнуудын гэр-ажил:

2024: 230.87

2023: 185.56

Хамрах хүрээ2 (тнCO2e)



Эрчим хүч:

2024: 2,627.67

2023: 881.3



Санхүүжилт:

2024: 728,506

2023: 447,590



Дулаан:

2024: 2,281.9

2023: 278.52




Хөрөнгө оруулалт:

2024: 1,044,828

2023: 582,892

Хамрах хүрээ3 санхүүжүүлсэн (тнCO2e)



- Хамрах хүрээ1: 5%
- Хамрах хүрээ2: 0.3%
- Хамрах хүрээ3 (бусад): 0.1%
- Хамрах хүрээ 3 (санхүүжүүлсэн): 95%



Хүлэмжийн хийн
шингээлт:

1,770тнCO2e**

*2023 оны тооцоололд өөрчлөлт орсон болно. Хавсралт хэсгээс дэлгэрэнгүй тайлбар харна уу.

**Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин нийт хугацаанд 385,838 ширхэг мод тарьж 1,770тнCO2e шингээн хувь нэмрээ оруулсан байна.



ЗАСАГЛАЛ





ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОН ЦАГИЙН ТОВЧОО

Дэлхий дахинд тулгараад буй уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь банкны харилцагчид болон банканд нэг талаас эрсдэл дагуулж байгаа ч нөгөө талаас боломжийг бий болгож байна. Өөрөөр хэлбэл хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахын тулд зах зээлийн голлох салбаруудад хөрөнгө оруулалт шаардлагатай болоод байгаа бөгөөд Голомт банк болон харилцагчдад ногоон, тогтвортой эдийн засгийн шилжилт хийх зайлшгүй шаардлага тулгарч буй тул банк нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, дасан зохицоход чухал үүрэг, хариуцлага хүлээн ажиллаж байна.

2015 - 2017

Тогтвортой хөгжийн бодлого батлав

2018 - 2019

Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого батлав

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Санхүүгийн санаачилга "Хариуцлагатай Банкны Зарчмууд"-д албан ёсоор нэгдэв

2020

Жендэрийн тэгш байдлын хороо байгуулав

Тогтвортой хөгжлийн жилийн тайлан гаргаж эхлэв

2021

Тогтвортой хөгжлийн хороо байгуулагдав

Тогтвортой хөгжлийн стратеги 2022-2025 батлав

2022

Тогтвортой санхүүжилтийн хэлтэс байгуулагдав

Тогтвортой ногоон бүтээгдэхүүнүүд гаргаж эхлэв

2023

Хүлэмжийн хийн тооцоолол, санхүүгийн бүртгэлийн түншлэл (PCAF)-д нэгдэв

Өөрийн үйл ажиллагаа болон санхүүжүүлсэн ХХЯ тооцоолол хийж эхлэв

Уур амьсгал болон усны менежментийн зорилтуудыг эцэслэн батлав

2024

Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт батлав

СТОУС S1 болон S2 стандартын хэрэгжилтийг хангах бэлэн байдлын ажил эхлэв

Хүлэмжийн хийн тооцооллын өгөгдлийн бүрэн бүтэн байдал, чанарыг дээшлүүлэх ажил эхлэв

Ногоон санхүүжилтийн нөлөөллийг хэмжиж эхлэв

СТРАТЕГИ

Голомт банк нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг бизнесийн стратегид бүрэн тусгаж, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр баримт бичиг болон Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахад хувь нэмрээ оруулан, ногоон санхүүгийн хүчирхэг тогтолцоог бүрдүүлэхийн төлөө бүхий л хүчин чармайлтаа гарган ажиллаж байна

СТРАТЕГИ ЗОРИЛГО #1 Тогтвортой засаглал



Өөрийн болон харилцагчдын ногоон, тогтвортой эдийн засгийн шилжилтийг хийх зорилго, төлөвлөгөөг хэрэгжүүлэх

СТРАТЕГИ ЗОРИЛГО #2 Тогтвортой, ногоон санхүүжилт



Тогтвортой, ногоон санхүүжилтийн хүрээг тэлэх



СТРАТЕГИ ЗОРИЛГО #3 Уур амьсгалын эрсдэлийн удирдлага



Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах эрсдэлийг удирдах

СТРАТЕГИ ЗОРИЛГО #4 Олон талт оролцоог хангах



Зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд оролцогч талуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ

Голомт банк нь тогтвортой байдал, ногоон санхүүжилтийн чиглэлээрх оролцоог Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон удирдлагын багийн үүрэгт бүрэн тусгаж, ТУЗ, удирдлагын баг, мэргэшсэн баг зэргээс бүрдсэн гурван шатлалт засаглалын бүтцийг хэвээр хадгалан, тогтвортой байдал, ногоон санхүүжилтийн засаглалын стандартыг сайжруулсаар байна. Ингэснээр банкны тогтвортой байдлын стратегийн хэрэгжилттэй холбоотой ажлыг урагшлуулах бат бөх суурийг тавьсан байна.

ГОЛОМТ БАНК ХК-ИЙН УУР АМЬСГАЛ, БОНЗ-ЫН ЗАСАГЛАЛЫН БҮТЦИЙН ТОЙМ

ТУЗ-ИЙН УУР АМЬСГАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛД ТАВИХ ХЯНАЛТ		
Голомт Банк ХК-ийн ТУЗ		
Эрсдэлийн Хороо	Аудитын Хороо	Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын Хороо
УДИРДЛАГЫН ТҮВШНИЙ ЗАСАГЛАЛ		
Гүйцэтгэх		
Эрсдэлийн Удирдлагын Хороо	Удирдлагын Хороо	
ДЭМЖИХ ЗАСАГЛАЛ		
Удирдлага		
Тогтвортой Хөгжлийн Хороо	Жендэрийн Тэгш Байдлын Хороо	Тогтвортой санхүүжилтийн хэлтэс

Голомт банк нь 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар уур амьсгалын өөрчлөлт, БОНЗ-той холбоотой хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Тогтвортой санхүүжилтийн хэлтэс, шийдвэр гаргалт хяналтыг хийх удирдлагын түвшний Тогтвортой Хөгжлийн Хороо болон Жендэрийн тэгш байдлын хороо, шаардлагатай тохиолдолд Удирдлагын хороогоор дамжуулан хийж байна. Голомт банк нь цаашид дээрх Гүйцэтгэх захирлын харъяа Эрсдэлийн Удирдлагын Хороо болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын үүрэгт тусгах ажлыг хийж эхлээд байгаа ба дээрх зураглалд тусгасан засаглалын бүтцийг бий болгон бэхжүүлэхээр зорин ажиллаж байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ

ТУЗ-ИЙН ТҮВШИНД

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь банкны бүхий л стратегийн чиглэл, удирдлага, хяналтыг хариуцдаг. ТУЗ нь Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо гэсэн гурван байнгын хороотой. 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар ТУЗ нь нийт 4 хараат, 4 хараат бус гишүүнтэй ажилласан байна.

ТУЗ нь банкны урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, стратегийг хариуцах бөгөөд хороод нь стратегийн шийдвэрийг хянаж, удирдан чиглүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжууд, БОНЗ-ын хэрэгжилтийг хянах, удирдах тогтолцоог бэхжүүлэхээр ажиллаж буй. Мөн стратегийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлүүдийг хянах, удирдах; Парисын хэлэлцээрийн дагуу банкны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг бууруулах, банкны өдөр тутмын үйл ажиллагааг илүү ногоон болгоход анхааран ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ТУРШЛАГА БОЛОН МЭРГЭШИЛ

Манлайллын туршлага

Санхүүгийн салбар дахь гүйцэтгэх удирдлагын туршлага (>10 жил)	       
Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн	  

Мэргэшил

Хөрөнгө оруулалтын менежмент	
Санхүү/ аудит	 
Эрсдэл, хууль эрх зүй / нийцэл	
Хүний нөөц, компанийн соёл	
БОНЗ	



Холбоос: ТУЗ-ийн гишүүд

2024 оны байдлаар ТУЗ-ийн гишүүд Компанийн Засаглалын Институтаас явуулсан дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд:

№	Хамрагдсан сургалтын мэдээлэл	Сургалтын хугацаа	Сургалтын үргэлжлэх хугацаа	Сертификат авсан эсэх
1	Best Practice in ESG and Risk Management	4 cap	2024.01.10 - 04.10	Тийм
2	Integrating ESG into Business Strategy	4 cap	2024.01.10 - 04.11	Тийм

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ

УДИРДЛАГЫН БАГИЙН ОРОЛЦОО БОЛОН ДЭМЖИХ ЗАСАГЛАЛ

Удирдлагын багийн гишүүн бүр өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд стратегийн болон бизнесийн шийдвэрийг 2050 он хүртэлх БОНЗ-ын зорилго зорилтод нийцүүлэн гаргах үүрэгтэй ба Хороодоор дамжуулан мэдээлэл авах, шийдвэр гаргах, хяналт хийн ажиллаж байна. БОНЗ-ын бодлогын хэрэгжилтийг хангах, банкны бусад нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тусдаа бүтэц ажиллаж байгаа юм.



	Тогтвортой хөгжлийн хороо	Жендэрийн тэгш байдлын хороо	Тогтвортой санхүүжилтийн хэлтэс
Дарга	Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх захирал	1 захирал
Гишүүд	Гүйцэтгэх удирдлагын баг	Гүйцэтгэх удирдлагын баг	3 менежер, 2 БОНЭҮнэлгээчин ³
Үндсэн үүрэг	Банкны тогтвортой санхүүжилт, тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилтэд хяналт тавих	Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, дотоод үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах	Банкны тогтвортой хөгжлийн бодлого болон стратегийн хэрэгжилтийг хангах, чиглүүлэх, олон улсын болон үндэсний стандартын хэрэгжилтийг хангах, уур амьсгалын өөрчлөлтийн харилцагчдын БОН эрсдэлийг үнэлэх, ногоон санхүүжилтийг тодорхойлох, баталгаажуулах, тайланг олон талд хүргэх
Хурлын давтамж	Доод тал нь жилд 2 удаа	Доод тал нь жилд 2 удаа	

2024 онд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн СТОУС S1 болон S2-ийн хүрээнд хэрэгжүүлэх тухай хороогоор хэлэлцэж хамаарал бүхий нэгжүүдийн төлөөлөгч нараас бүрдсэн ажлын хэсэг Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдаж, банкны бэлэн байдлын үнэлгээ болон хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг хамтран гаргалаа. Уг ажлын хүрээнд ажлын хэсэг нь биет болон биет бус уулзалтыг хийж, үр дүнг тухай бүрд танилцуулан баталгаажуулахаас гадна, мэдлэг олгох сургалт аван амжилттай ажиллаа.


2030 БОЛОН 2050 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Голомт банкны хувьд Парисын хэлэлцээрийн зорилгуудтай санхүүжилтийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа уялдуулж, дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2 хэмээс хэтрүүлэхгүй буюу 1.5 хэмд хязгаарлах зорилттой нийцүүлэхээр зорилго зорилт тавин ажиллаж байна. Түүнчлэн Монгол улсын Үндэсний Зорилтот Хувь Нэмэр (ҮЗХН) баримт бичгийг харгалзан үзэж, 2030 он болон 2050 он гэхэд нийт зээлийн багцаар дамжуулан санхүүжүүлсэн болон өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг 30 хувь болон 50 хувиар тус тус бууруулах амбицлаг зорилгыг тавин, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ЗОРИЛГО #1:

Уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг
бууруулах

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах



≈ 2030 онд

↓ 30%

≈ 2050 онд

↓ 50%

ЗОРИЛГО #2:

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг
бууруулах

Усны нөөцийг шавхагдахаас сэргийлэх



≈ 2030 онд

↓ 5%

≈ 2050 онд

↓ 10%



ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ




ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ

Уур амьсгалын өөрчлөлт нь нэг талаас зээлийн багцад эрсдэл бий болгодог ч нөгөөтэйгөөр банк санхүүгийн байгууллага нь олгож буй санхүүжилтээрээ дамжуулан эерэг нөлөөлөл авчрах боломжтой. Иймээс Голомт банк нь тогтвортой, ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдадаа санал болгох замаар ногоон бизнесийн шилжилт хийхээр, шинэ боломжуудыг нээн ажиллаж байна.



4,717

АЖЛЫН БАЙР



99

ТЭРБУМ ₮




2024 оны 12-р сарын 31-рх банкны нийт ногоон зээлийн багцаар дамжуулан 4,717 ажлын байрыг бий болгож 99 тэрбум төгрөгийн нэмүү өртөгийг хадгаламж, татвар болон цалин хэлбэрээр бий болгон тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулсаар байна.

Уг тооцооллыг Joint Impact Model /JIM/-ын хэрэгслийг ашиглан нийгэмд үзүүлж буй нөлөөллийг гаргав. Голомт Банк "Joint Impact Model Foundation" байгууллагад 2024 оны 3-р сарын 15-ны өдөр албан ёсны гишүүнээр элсэж, олгож буй санхүүжилтээр дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хий, шинээр бий болгож буй ажлын байрны тоо болон эдийн засгийн өсөлтөд хэрхэн хувь нэмрээ оруулж байгаа зэргийг олон улсын аргачлалын дагуу тооцоолон, бодит нөлөөллийг хэмжээд байна.

ТОГТВОРТОЙ, НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ

Банк нь 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувийг тогтвортой, ногоон зээлийн багцаар бүрдүүлэх зорилтыг тавьж, үүний хүрээнд өнгөрсөн таван жилийн хугацаанд нийт 875 тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгожээ. Үүнээс 2024 онд нийт 308 (2023: 243 тэрбум төгрөг) тэрбум төгрөгийн ногоон санхүүжилт олгосон ба 2024 оны 12-р сарын 31-ний байдлаарх тогтвортой, ногоон зээлийн багц 265 (2023: 183 тэрбум төгрөг) тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2030 ОН ХҮРТЭЛХ НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



- Сэргээгдэх эрчим хүч
- Бохирдол багатай эрчим хүч
- Эрчим хүчний хэмнэлт
- Ногоон барилга
- Бохирдлоос сэргийлэх, бууруулах
- Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ
- Тогтвортой ХАА, ой болон эко аялал жуучлал
- Карбон бага ялгаруулдаг тээвэр
- Орлогод нийцсэн орон сууц
- Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хүнсний аюулгүй байдал
- Нийгэм эдийн засгийн өсөлтийг бэхжүүлэх

Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг санхүүжүүлэх таксономи болон банкны Тогтвортой санхүүжилтийн хамрах хүрээ баримт бичгийн хүрээнд Голомт банк боловсрол, эрүүл мэнд, орлогод нийцсэн орон сууц, мэдээлэл технологи гэх мэт чиглэлээр нийгмийн санхүүжилтүүдийг олгохоор бэлтгэл ажлаа хангах, шалгуур шаардлагуудаа нарийвчлан тодорхойлох ажлуудыг хийж буй. Үүний нэг жишээ бол Азийн хөгжлийн банк, ТоС Холбоо болон Монгол дахь НҮБ хамтран Голомт банкны 2023 оны 12-р сарын 31-рх зээлийн багцад дээрх ангилалд орох боломжтой зээлүүдийг тодорхойлон гаргасан ажил билээ. Энэхүү тайлантай [ЭНД ДАРЖ](#) дэлгэрэнгүй танилцана уу.

ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ

Голомт банк нь дараах бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэн харилцагчиддаа санал болгож байна.

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН

	Хүү	Дээд хэмжээ	Хугацаа (сар)
Тогтвортой, ногоон бизнесийн зээл (гадны болон өөрийн эх үүсвэр)	1.2% - 1.4%	5-10 тэр.төг.	30-84
Хүү хуваан төлөх нөхцөлтэй ногоон зээл	1.2% - 1.4%	5-10 тэр. төг.	84
Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл	1.2% - 1.4%	ЭХЗ – 500сая төг хүртэл, ХОЗ – 1тэрбум төг хүртэл	36


ИРГЭДЭД ЗОРИУЛСАН

	Хүү	Дээд хэмжээ	Хугацаа (сар)
Ногоон амины орон сууцны зээл	EDGE Certified: Бодлогын хүү+4%, EDGE Advanced болон CARBON ZERO: Бодлогын хүү+2% буюу 2024.12.31-ээрх хүү: 1%-1.17%	160-300 сая төг.	120-240
Автомашины ногоон зээл	1.2%-1.25%	Бүтээгдэхүүний үнийн дүнгээс хамаарна	30-96
Ногоон хэрэглээний зээл	1.25%	20 сая төг.	30
Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, амины орон сууцны зээл	1.25%	Худалдан авч буй ОС, АОС-ны жишиг үнийн дүнгийн 80%-100% хүртэл	240

Банкны ногоон зээлийн багцын бүрдлийг ангилан харвал эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөдөө аж ахуй, тогтвортой ус, хог хаягдлыг дэмжих санхүүжилт нь 97.53%-ийг бүрдүүлж байна.

Таксономийн ангилал	2022Q4 (%)	2023Q4 (%)	2024Q4 (%)
Сэргээгдэх эрчим хүч	0.07	-	-
Карбон бага ялгаруулдаг тээвэр	1.20	0.66	1.91
Эрчим хүчний хэмнэлт	0.05	52.41	64.35
Ногоон барилга	57.38	-	-
Бохирдол багатай эрчим хүч	-	0.41	0.11
Тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал зуучлал	20.87	41.89	21.92
Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ	20.43	4.62	11.26
Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа	-	-	0.45

НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ, СЕГМЕНТЭЭР



ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ

1. Эрчим хүчний хэмнэлт (2024: 64.35%)

Доод тал нь 20 хувийн эрчим хүчний хэмнэлт гарган баталгаажуулсан дараах санхүүжилтүүд орно. Үүнд:

- эрчим хүчний хэмнэлттэй орон сууц/үйлчилгээ/оффисын барилга барих,
- эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж/гэр ахуйн цахилгаан бараа худалдаж авах,
- эрчим хүчний хэмнэлттэй орон сууц/үйлчилгээний талбай худалдаж авах санхүүжилтууд багтсан болно.


2. Тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал зуучлал (2024: 21.92%)

Таксономийн шалгуур ханган баталгаажсан тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээтэй, тойрог бизнесийн модельтой санхүүжилтүүд орно.


3. Тогтвортой ус, хог хаягдлын хэрэглээ (2024: 11.26%)

- Доод тал нь 20 хувийн усны хэмнэлт бий болгох тоног төхөөрөмж худалдан авах,
- Аюултай болон аюулгүй хог хаягдлыг МУ-ын журам, стандартын дагуу цуглуулах/тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах санхүүжилтүүд орно.

Эх үүсвэрээр (2024)



Байршлаар (2024)




НОГООН БИЗНЕСИЙН ШИЛЖИЛТИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ НЬ


Тогтвортой, ногоон санхүүжилтийн бизнесийн багцыг задлан харахад 2024 онд бид:

1. Ногоон санхүүжилт авах боломжтой харилцагчдыг тодорхойлох, мэдээллээр хангах, хамтран ажиллах ажлыг хийснээр Таксономийн дагуух ангиллын тоог дөрвөөс зургаа болгон нэмэгдүүлсэн байна.
2. Банкны хэмжээнд тавьсан дунд болон урт хугацааны зорилтуудын хүрээнд тогтвортой ус, хаягдлын хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой олгосон санхүүжилтийн хувь 4.75 хувиас 12.44 хувь болон өссөн байна.

Ногоон бизнесийн зээлийн багц (2023Q4)



Ногоон бизнесийн зээлийн багц (2024Q4)



ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ

ИРГЭДИЙН НОГООН ХЭРЭГЛЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ НЬ


Бид харилцагч төвтэй банкны үйлчилгээ буюу хадгаламж, харилцах, дижитал банк, зээл, картын бүтээгдэхүүн, гадаад төлбөр тооцоо, даатгал зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсын өнцөг булан бүрд суугаа нэг сая гаруй харилцагчдаа салбар тооцооны төвүүд болон цахим сувгуудаар хүргэн ажиллаж буй.

Банк нь тогтмол хувьсан өөрчлөгдөж буй харилцагчдын хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэх, тогтвортой амьдралын хэв маягийг бүрдүүлэх зорилготой дижитал шилжилтийг эрчимтэй хийж, илүү хүртээмжтэй, тогтвортой, ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгосоор байна. Үүнд:


Тогтвортой, ногоон санхүүжилтийг авсан иргэдийн багцыг задлан харахад 2024 онд бид:

1. Ногоон санхүүжилт авах боломжтой харилцагчдыг тодорхойлох, мэдээллээр хангах, иргэдэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулан хамтран ажиллах ажлыг хийснээр Таксономийн дагуух ангиллын тоог хоёроос дөрөв болгон нэмэгдүүлсэн байна.

Тогтвортой, ногоон хэрэглээний зээлийн багц (2023Q4)



Ногоон бизнесийн зээлийн багц (2024Q4)



БИДНИЙ ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Бид тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүнээр дамжуулан байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөөллийг харилцагчид нартайгаа хамтран бий болгож, эерэг нөлөөллийг нь хэмжин “Тогтвортой, ногоон санхүүжилтийн сайн туршлагууд” цахим товхимлыг 2024 онд гаргаж сайн жишээг түгээж байна. Зарим жишээтэй танилцана уу.

Харилцагч	Зээлийн зориулалт	Таксономийн ангилал	Санхүүжүүлсэн дүн	Эерэг нөлөө	Хамаарах ТХЗ
Хидро Инженеринг	Төвийн цахилгаан станцаас алслагдсан бүс нутагт нарны эх үүсвэрээр эрчим хүч үйлдвэрлэх панел суурилуулах	1.2.2 Жижиг хэмжээний нарны цахилгаан үүсгүүр	307 сая	Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт хэрэгжих “Байгаль орчноо хамгаалах загас үржүүлэх загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-д нийт 80ш 500Вт -ын нарны дэлгэцийг суурилуулах ажлыг гүйцэтгэлээ.	
Горгаз ХХК	Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй цэцэрлэг, сургууль, төрийн байгууллагын нам даралтын зуухыг хийн зуухаар солих	2.2.1 Хийн түлш ашиглан цахилгаан болон дулаан үйлдвэрлэх	1.3 тэрбум	Нийслэлийн 152-р сургууль, 148-р сургууль болон 109-р сургуулиудын нам даралтын зуухыг хийн зуухаар сольж жил бүр хэрэглэдэг байсан 2645 тн нүүрсний хэрэглээг халж, 1091 тн үнсний хаягдал үүсэхээс сэргийлж чадсан байна.	
Драгон Холдинг ХХК	28%-н Эрчим хүчний хэмнэлттэй “Зорчигч тээврийн терминал” үйлчилгээний цогцолбор барих	3.3.1 Эрчим хүчний хэмнэлттэй шинэ барилга барих	39 тэрбум	Жилд эрчим хүчний хэрэглээнээс 422тнC02e хүлэмжийн хий бууруулна. Шинээр 1,800 ажлын байр бий болно.	
Электрокем Монгол ХХК	Хар тугалганы батерей дахин боловсруулах үйлдвэр барих	6.2.1 Хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжууд, үйл ажиллагаа	7.6 тэрбум	Жилд 340,000 ширхэг батарей боловсруулах хүчин чадалтай ба жил бүр энэ хэмжээгээр үүсэх хаягдлыг үгүй болгож байна. Жилд 1,000 тн хүхрийн хүчлийн уусмал хаягдахаас сэргийлнэ.	
Цэцүүх трейд ХХК	Дахин боловсруулах түүхий эд хадгалах агуулах барих, тээвэрлэх ачааны машин худалдан авах	6.2.1 Хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжууд, үйл ажиллагаа	4.5 тэрбум	Жилд 500 тн аюултай хуванцар байгальд хаягдахаас сэргийлж байна.	

Тогтвортой, ногоон санхүүжилтийн сайн туршлагуудын дэлгэрэнгүй товхимолтой [ЭНД ДАРЖ](#) танилцана уу.

САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛСАН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

2024 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт санхүүжилтээр дамжуулан ялгаруулсан хүлэмжийн хий 728,506тнCO₂e (2023: 447,590тнCO₂e⁴), хөрөнгө оруулалтаар дамжуулан ялгаруулсан хүлэмжийн хий 1,044,828тнCO₂e (2023: 582,892тнCO₂e) байна. Банкны нийт санхүүжүүлсэн ХХЯ-ын 89 (2023: 84 хувь) хувийг бизнесийн зээлийн багц бүрдүүлж байна. Голомт банк нь хүлэмжийн хийн тооцооллыг PCAF аргачлалын дагуу дараах байдлаар ангилан хийсэн ба бусад зориулалтаар иргэдэд олгосон зээлийн багц дээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал байхгүй тул иргэдийн бусад зээлийн багц дээр тооцоолол хийгээгүй болно. Өөрөөр хэлбэл банкны тайлант оны нийт багцын 74 хувь дээр санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг тооцсон байна. 2024 оноос эхлэн PCAF ангиллын засгийн газрын өр, худалдан авсан бонд, хувьцаа ангиллын буюу хөрөнгө оруулалтаас үүдэн гарч буй хүлэмжийн хийн тооцооллыг тооцож эхлэв.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2024 он	2023 он ⁵
PCAF хөрөнгийн ангилал	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO ₂ e)	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO ₂ e)
 Бизнесийн зээл	646,390	377,452
 Орон сууцны зээл	58,486	52,119
 Үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зээл	15,991	10,461
 Автомашины зээл	6,902	5,223
 Төслийн санхүүжилт	736	2,334
Нийт	728,506	447,590


Өрийн болон өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

	2024 он	2023 он ⁶
PCAF хөрөнгийн ангилал	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO ₂ e)	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO ₂ e)
 Засгийн газрын өр	1,012,064	564,521
 Биржид бүртгэлтэй хувьцаа болон компанийн бонд	32,765	18,371
Нийт	1,044,829	582,892

⁴Тогтвортой хөгжлийн тайлан 2023 оны тайланд нийт санхүүжүүлсэн ХХЯ-ын 1.6 сая тнCO₂e гэснийг 447,590тнCO₂e болгон засав. Энэхүү зөрүү нь PCAF аргачлалын хүрээнд харилцагч тус бүрийн оны эцсээрх нийт эздийн өмч болон нийт өр төлбөрийн мэдээлэл дутуу авсныг засан банкнын хамаарал бүхий ХХЯ хэмжээг нарийвчлан гаргасантай холбоотой.

⁵2023 оны тооцооллыг сайжруулан залруулав. Хавсралт хэсгээс дэлгэрэнгүй тайлбартай танилцана уу.

⁶2023 оны хөрөнгө оруулалтын хүлэмжийн хийн тооцооллыг энэхүү тайлант онд харьцуулах үүднээс PCAF аргачлалаар нөхөн тооцоолов.



Нийт санхүүжүүлсэн ХХЯ дүн өмнөх тайлант онтой харьцуулахад 63 хувийн өссөн үзүүлэлттэй байгаа ба энэ нь банкны нийт багцын өсөлттэй шууд хамааралтай байна. Банкны нийт зээлийн багц өмнөх онтой харьцуулахад 35 хувийн өсөлт үзүүлсэн байна.

САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААРХ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ /2023 БА 2024 ОНУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ/

ISIC код	Эдийн засгийн ангилал	2024 он / тнCO2e/	2023он / тнCO2e/		Өөрчлөлтийн хувь
ISIC-A	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	47,480	13,461	▲	252%
ISIC-B	Уул уурхай, олборлолт	330,156	163,074	▲	102%
ISIC-C	Боловсруулах үйлдвэрлэл	64,683	76,169	▼	-15%
ISIC-D	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	35,051	9,528	▲	267%
ISIC-E	Усан хангамж; бохир ус, хог,хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	570	696	▼	-18%
ISIC-F	Барилга	38,378	29,256	▲	31%
ISIC-G	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	113,424	82,138	▲	38%
ISIC-H	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	10,230	3,646	▲	180%
ISIC-I	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2,781	2,112	▲	31%
ISIC-J	Мэдээлэл, холбоо	577	335	▲	72%
ISIC-K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1,007	548	▲	83%

ISIC-L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	66,581	57,085	▲	16%
ISIC-M	Мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн; захиргааны үйл ажиллагаа	117	219	▼	-46%
ISIC-N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	48	54	▼	-11%
ISIC-O	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	32	12	▲	166%
ISIC-P	Боловсрол	1,361	931	▲	46%
ISIC-Q	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,301	1,582	▲	45%
ISIC-R	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	199	76	▲	161%
ISIC-S	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11,016	4,962	▲	122%
ISIC-T	Өрхийн ажил олгогчийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэгцээнд зориулан ялгаваргүй бараа, үйлчилгээ үйлдвэрлэх үйл ажиллагаа	30	1	▲	2900%
ISIC-U	Нутаг дэвсгэрээс гадуурх байгууллага, үйл ажиллагаа	2,486	1,704	▲	46%
Нийт	728,506	447,590		▲	63%

САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

ХХЯ ӨНДӨР САЛБАРУУД БА БУУРУУЛАХ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Банкны тодорхойлсон хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг салбаруудын санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ 592 (2023: 352 мянга) мянган тнCO₂e байна. Үүнд:



Хөдөө аж ахуй
47,480тнCO₂e



Эрчим хүчний хуваарилалт ба дамжуулалт
35,051тнCO₂e



Уул уурхай
330,156тнCO₂e



Тээвэр ба агуулах
10,230тнCO₂e



Боловсруулах үйлдвэрлэл
64,683тнCO₂e



Барилга ба Үл хөдлөх
38,378 ба 66,581

Тайлант онд уул уурхай болон барилга ба үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа гэсэн хоёр эдийн засгийн салбарт зорилтууд тавин ажиллахаар тодорхойлон бизнес төлөвлөгөөнд оруулан батлуулсан байна. Үүнд:

Уул уурхай

Монгол Улсын тэргүүлэх салбар болох уул уурхайн салбар нь 2024 онд улсын төсвийн 30 хувийг дангаар бүрдүүлжээ. Тус салбарын байгаль орчин болон нийгэмд үзүүлэх үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл өндөр тул Голомт банк зээл олголтоос өмнө байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийн бууруулах зөвлөмжүүдийг өгөх, гүйцэтгэлийг хянах байдлаар харилцагчидтайгаа хамтран ажиллаж байна.

Энэхүү багцад байгалийн нөөцийн олборлолт, хайгуул хийж буй ААН болон холбогдох үйл ажиллагаанд туслан гүйцэтгэх үйлчилгээ үзүүлж буй ААН-үүдэд олгосон зээлүүдийг хамааруулан авч үзнэ. Олгосон санхүүжилтийг төрлөөр нь авч үзэхэд эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалт болон лизингийн санхүүжилтүүд багтаж байна.



Иймээс, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй харилцагчдын ногоон шилжилтийг дэмжсэн хөрөнгө оруулалт тэр дундаа тогтвортой усны менежмент, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, тоног төхөөрөмж барих, худалдан авах болон лизингийн үйлчилгээгээр дамжуулан байгаль орчинд ээлтэй хүнд даацын болон бусад машин механизмыг санхүүжүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, мэдээллээр ханган хамтран ажиллахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Цаашид Голомт банк нийт уул уурхайн салбарын зээлийн багцыг ногооруулах нарийвчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг ил тод нээлттэй байдлаар тайлагнан хянаж ажиллах болно.



Барилга ба үл хөдлөх хөрөнгө

Тайлант үеэрх барилга болон үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн багцын 8 хувийг бид доод тал нь 20 хувийн эрчим хүчний хэмнэлттэй барилга барихад олголоо. Банк нь энэхүү санхүүжилтийг гадаад болон өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа ба шалгуур болон баталгаажуулалтыг Ногоон таксономи болон гаднын хөрөнгө оруулагчдын шаардлагад нийцүүлэн баталгаажуулан ажиллаж байна. Бид өөрсдийн тавьсан зорилго зорилтдоо хүрэхийн тулд нийт барилга болон үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны багцад эзлэх эрчим хүчний хэмнэлттэй барилга барих, худалдан авах багцын хэмжээг 2030 он гэхэд 30 хувь хүргэхээр зорин ажиллаж буй.

Ногоон зээлийн багцын хяналтыг улирал бүр баталгаажуулах баримтын хамт тулган шалган шүүж, Монгол банканд хүргүүлэн, цаг тухай бүрд дотооддоо мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.





ТОГТВОРТОЙ,
НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ӨӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Голомт банк нь өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй ХХЯ-ыг бууруулах, нөөцийг хариуцлагатай, тогтвортой ашиглах замаар байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах үүрэг хариуцлагыг хүлээн ажиллаж байна. Үүний хүрээнд, бид өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг 2030 он болон 2050 он гэхэд 30 болон 50 хувиар тус тус бууруулах зорилтуудыг баталсан юм.

56% ↓



2024 онд нийт өөрийн үйл ажиллагаанаас ялгарч буй хүлэмжийн хийн хэмжээг 2023 суурь оны шинэчилсэн тооцоололтой харьцуулахад 56 хувиар бууруулж чадсан байна. Бензин, түлшний зардлын бууралт нь энэхүү бууралтад гол нөлөө үзүүлжээ.

Банк нь өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг дараах байдлаар ангилан тооцдог.

	2024 /тнCO2e/	2023 /тнCO2e/
Хамрах хүрээ 1		
Бензин	62,654.13	123,395.10
Дизель	33,476.45	108,399.12
Хөргөгч, хөргүүр	0.41	-
Агааржуулагч	34.07	-
Нийт	96,165.07	231,794.22
Хамрах хүрээ 2 (байршилд суурилсан)		
Эрчим хүч	2,627.67	881.30
Оффис	830.95	881.30
Салбарууд	1,796.72	-
Дулаан	2,281.93	278.52
Оффис	667.56	278.52
Салбарууд	1,614.37	-
Нийт	4,909.61	1,159.82

Хамрах хүрээ 3 (бусад)		
C5: Хог хаягдал	2,050.77	2,175.73
C6: Гадаад томилолт	166.24	145.44
C7: Ажилтнуудын гэр-ажил маршрут	230.87	185.56
Нийт	2,447.88	2,506.73
НИЙТ ХХЯ (Хамрах хүрээ 1,2,3(бусад))	103,522.55	235,460.77 ⁷

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ

Хамрах хүрээ 1

- Өөрийн эзэмшлийн болон түрээсийн тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалт болон агааржуулагч, хөргөгч хөргүүрээс ялгарч буй хүлэмжийн хийг хамруулан авч үзнэ.
- 2024 оноос эхлэн банкны эзэмшлийн хөргөгч, агааржуулагчаас ялгарч буй хүлэмжийн хийг тооцоолж эхлэв.
- Хамрах хүрээ 1 хүрээнд ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарал 64 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь нийт бензин түлшинд зарцуулж буй зардал буурсантай холбоотой. Цаашид мөн бензин түлшний зардлыг бууруулах, электрон машин руу шилжихэд анхаарна.
- Хүлэмжийн хийн тооцооллын протоколын (GHG Protocol) стандарта болон Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг засгийн газар хоорондын зөвлөл (IPCC)-с гаргасан зөвлөмжийг ашиглав.

Хамрах хүрээ 2

- Оффис, салбаруудын эрчим хүч, халаалт, дулааны ашиглалт
- 2024 оноос эхлэн салбаруудын эрчим хүч, дулааны ашиглалтыг бүртгэж, хэрэглээг гаргах боломжгүй 60 салбарууд дээр талбайн хэмжээнд үндэслэн тооцоолол хийв. Цаашид салбар бүрийн хэрэглээг бүртгэн өгөгдлийг сайжруулахаар ажиллаж байна.
- Оффисуудын эрчим хүчний хэрэглээнээс ялгарч буй хүлэмжийн хийн хэмжээ 5 хувиар буурсан байна.
- Харин оффисуудын дулааны хэрэглээ өссөн байгаа нь 2023 оны тооцоололд 2 оффисын мэдээлэл ороогүй байгаатай холбоотой. 2024 онд өгөгдлийг сайжруулж нийт 5 оффисуудын хэрэглээг бүртгэлжүүлсэн юм.
- Хүлэмжийн хийн тооцооллын протоколын (GHG Protocol) стандарт болон Эрчим хүчний зохицуулах хорооны “Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал” ашиглав.
- Байршилд суурилсан аргаар тооцоолов.

⁷2023 оны тооцооллыг шинэчилсэн болно. Метрикийн зөрүү байсныг энэ жил засан дахин тооцоолов. Хавсралт хэсгээс дэлгэрэнгүй тайлбар харна уу.

Хамрах хүрээ 3 (бусад)

- Гадаад томилолт, хог хаягдал, усны ашиглалт, ажилтнуудын гэр ажлын хооронд зорчиж буй хэлбэрээс ялгарч буй хүлэмжийн хийг тооцоолов.
- Хог хаягдлын хувьд дахин боловсруулах боломжтой картон цаас, хуванцар, шил, хуруу зайнаас ялгарч буй хүлэмжийн хий болон бусад хог хаягдлыг хамруулж байна.
- Нийт ашигласан усны хэмжээг бүртгэх боломжгүй байгаа салбаруудын хувьд талбайн хэмжээнд харьцуулан тооцоолсон.
- Бизнес томилолтын хувьд одоогоор зөвхөн агаараар зорчсон гадаад болон дотоод томилолтууд дээр тооцооллыг хийж байна.
- Ажилтнуудын ажил гэр хооронд зорчих хэлбэрийг ажилтнуудаас судалгаа аван тээврийн хэрэгслийн төрөл, зай (км), 7 хоногт ажилласан цаг зэрэг мэдээллүүдийг ашиглаж байна. Ажилтнуудын тоо нэмэгдсэн нь энэхүү ангиллын өсөлтөд Хүлэмжийн хийн тооцооллын протоколын (GHG Protocol) стандартын дагуу тооцоолов.

Баталгаажуулалт

- 2024 оны хүлэмжийн хийн тооцоололд Дотоод Аудитын Газраас баталгаажуулалт авсан болно.



Өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг бууруулах чиглэлээр 2024 онд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

ТОГТВОРТОЙ, НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭВ

Өөрийн үйл ажиллагааг илүү ногоон болгох, ажилтнуудын ажиллах болон үйлчлүүлэгчдийн үйлчлүүлэх орчныг хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилготой “Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт”-ыг батлан ажиллаж байна. Уг стандарт нь дараах бүлгүүдээс бүрдсэн байна.

- Тогтвортой, ногоон худалдан авалтын стандарт
- Тогтвортой, ногоон засвар үйлчилгээний стандарт
- Тогтвортой, ногоон цэвэрлэгээний стандарт
- Тамхигүй орчин бүрдүүлэх хязгаарлалтын стандарт
- Хортон шавжтай тэмцэх стандарт

Стандартын хураангуйтай [ЭНД ДАРЖ](#) танилцана уу.



АНУ-ЫН НОГООН БАРИЛГЫН ЗӨВЛӨЛ (USGBC)-ӨӨС ОЛГОДОГ LEED O+M “GOLD” ТҮВШНИЙ ГЭРЧИЛГЭЭ АВЛАА

АНУ-ын Ногоон Барилгын Зөвлөл (USGBC)-өөс олгодог LEED O+M (Leadership in Energy and Environmental Design – Operations and Maintenance) стандартын “GOLD” түвшний гэрчилгээг Төв оффисын барилга дээр амжилттай авч байгаль орчинд ээлтэй, тогтвортой менежменттэй барилга гэдгээ баталгаажууллаа. Уг гэрчилгээг барилгын ашиглалт болон өдөр тутмын менежмент нь:

- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулсан
- Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлсэн
- Усны зохистой хэрэглээг хангасан
- Агаарын чанарыг зохистой хэмжээнд барьсан
- Дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн зэрэг

үзүүлэлтүүдийг хангасан барилгуудад олгодог бөгөөд Голомт банкны төв оффис нь Монгол Улсаас LEED гэрчилгээг хүртсэн гурав дахь барилгаар бүртгэгдээд байна.



Төв оффисын барилга болох нийт 2,682 м2-д LEED гэрчилгээ авсан байна. Бид оффис, салбаруудаа ногоон, тогтвортой менежменттэй, байгаль орчин болон ажилтнууддаа ээлтэй байдлаар сайжруулахад анхааран ажиллаж байна. 2024 онд нийт оффисуудын **усны хэрэглээ 8.5 хувиар, эрчим хүчний хэрэглээ 9.7 хувиар буурсан** байна.

ТОГТВОРТОЙ, НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭРЧИМ ХҮЧ



Зорилт

- 2030 болон 2050 оны банкны хэмжээний зорилтууд (2030:30%, 2050: 50%)

Тогтвортой хөгжлийн бодлого

- Банкны дотоод үйл ажиллагаанд баримтлах бодлого бүлэгтээ "Эрчим хүч болон хүлэмжийн хийн ялгаралт: Дотоод үйл ажиллагаандаа эрчим хүчийг үр ашигтай, ариг гамтай хэрэглэхийг зорих" (заалт 3.6)

Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт

- ЭХ гэрэл, чийдэн, цахилгаан хэрэгсэл (заалт 2,4)

LEED Gold Standard

- Гэрлийн бохирдлыг бууруулалт;
- Эрчим хүчний хэмнэлтийн менежмент зэрэг үзүүлэлтүүдийг хангаж чадсан ба эрчим хүчний хөндлөнгийн аудит хийгдсэн.

УС



Зорилт

- 2030 болон 2050 оны банкны хэмжээний зорилтууд (2030:5%, 2050: 10%)

LEED Gold Standard

- Борооны усны менежмент;
- Усны хэрэглээ зэрэг үзүүлэлтүүдийг хангаж чадсан.

Худалдан авалтын үйл ажиллагааны журам (2023)

- 2.3.7.1 Хивс угаах процессыг агааржуулалт сайн, ажилчидгүй орчинд, хоруу чанар багатай цэвэрлэгээний бодисоор, бага ус ашиглан хийж гүйцэтгэнэ.

ХОГ ХАЯГДАЛ



Тогтвортой хөгжлийн бодлого

- Банкны дотоод үйл ажиллагаанд баримтлах бодлого бүлэгтээ "Хог хаягдлын менежмент: Агаар, ус, газар зэрэгт үзүүлж буй байгууллагын нөлөөллийг багасгахыг зорих;" (заалт 3.6.2.3)

Дахивар хог хаягдал

- Банк нь бүх оффис, салбартаа хог хаягдлыг ангилдаг бөгөөд дахивар хаягдлыг ачуулдаг.
- /шил, лааз, цаас/ /аюултай хог хаягдал ачих/аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах/ ***процессор, PC, монитор, батерей, гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмж, утас, принтер, цэнэг хуримтлуур, тог баригч г.м.

LEED Gold Standard

- Хог хаягдлын менежмент үзүүлэлтийг хангаж чадсан ба хог хаягдлын хөндлөнгийн аудит хийгдсэн.

ХУДАЛДАН АВАЛТ



Худалдан авалтын үйл ажиллагааны журам (2023)

- Үндэсний үйлдвэрлэл
- Байгаль орчин

Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт (2024)

- Тогтвортой, ногоон худалдан авалтын стандарт
- Автомашин, тавилга, тоног төхөөрөмж, принтер, мөнгө тоологч, бичиг хэрэг, хэвлэмэл материал, ариун цэврийн зүйлс (заалт 1.2.1)
- Үл хөдлөх, их засвар, урсгал засвар, интерьер дизайн гэх мэт шинэ нэгж байгуулахтай холбоотой (заалт 1.2.2)
- МТГ-тэй холбоотой сүлжээ, дэд бүтэц (заалт 1.2.3)

Эрчим хүч

	Хэмжих нэгж		2024		2023	2022
Оффис	кВт.ц	▼	1,066,481.32	▼	1,181,445	1,379,706
Салбар	кВт.ц	▼	608,631.45		-	-
Нарны эрчим хүчнээс	кВт.ц		(4,539)	▲	(6,376)	(5,987)
Нийт	кВт.ц	▲	1,670,573.77	▼	1,175,069	1,373,719

Голомт банкны оффисуудын эрчим хүчний хэрэглээ жил бүр буурч байгаа ба 2024 онд өмнөх онтой харьцуулахад 9.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин нийт эрчим хүчний хэрэглээний дүнг харахад 42.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь тайлант оноос эхлэн нийт 32 салбаруудын эрчим хүчний хэрэглээг хэмжин тайлагнаж эхэлсэнтэй холбоотой юм. Хүлэмжийн хийн тооцоололд орсон 91 салбаруудын 34 хувьд бодит цахилгааны хэрэглээг гарган тооцоолол хийсэн бол үлдсэн 66 хувийн салбаруудын цахилгааны хэрэглээг м2 дээр үндэслэн тооцоолж гаргасан болно. Энэхүү өгөгдлийн зөрүүг багасгах, цаашлаад арилгах зорилгоор салбаруудын эрчим хүчний хэрэглээний өгөгдлийг банкны хэмжээнд бүртгэх ажлыг өмнөх оноос эхлэн хэрэгжүүлсээр байгаа ба цаашид бүрэн бүтэн, чанарын шаардлага хангасан байхыг зорин ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад 9.7 хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгосноор банк 32,7 сая төгрөг⁸ (НӨАТ ороогүй) хэмнэсэн байна.

Ус

	Хэмжих нэгж		2024		2023	2022
Оффис	м3	▼	6,934	▶	7,581	7,349
Салбар	м3		1,562	▶	-	-
Нийт	м3	▲	8,496		7,581	7,349

Тайлант оны оффисын усны хэрэглээ өмнөх онтой харьцуулахад 8.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин нийт усны хэрэглээний дүн 12.1 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь тайлант оноос эхлэн 9 салбарт усны хэрэглээг хэмжиж эхэлсэнтэй холбоотой юм. Эрчим хүчний хэрэглээний өгөгдөлтэй адил Голомт банк нь салбаруудын усны хэрэглээг салбар тус бүрээр гаргах ажлыг өмнөх оноос эхлэн хэрэгжүүлсэн ба нийт салбаруудын 10 хувь нь бодит хэрэглээг гарган тайлагнасан бол үлдсэн салбаруудын усны хэрэглээг нэг хүний нэг өдрийн дундаж хэрэглээ дээр үндэслэн гаргасан байна. Энэхүү өгөгдлийн зөрүүг багасгах, цаашлаад арилгах зорилгоор салбаруудын усны хэрэглээний өгөгдлийг банкны хэмжээнд бүртгэлжүүлэх ажлыг өмнөх оноос эхлэн хэрэгжүүлсээр байгаа ба цаашид бүрэн бүтэн, чанарын шаардлага хангасан байхыг зорин ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад 8.5 хувийн усны хэрэглээг бууруулснаар банк 1,9 сая⁹ төгрөг хэмнэсэн байна.

⁸Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2024 оны 11-р сарын 1-нд батлагдсан 632-р тогтоолын дагуу энгийн тариф болох 285,00 төг/кВт.ц. (НӨАТ ороогүй) тооцсон болно.

⁹ХСУХАТАУЗЗ-ийн 2023 оны 11-р сарын 1-нд батлагдсан 96-р тогтоолын дагуу тодруулан дурдсанаас бусад ААН, байгууллага гэсэн ангилалын цэвэр усны тариф болох 2,959 төг./м3 тооцов.

Хог хаягдал

	Хэмжих нэгж	2024	2023	2022
Цаас /картон/	кг	▲ 415.1	171	143
Хуванцар	кг	▲ 624.7	366.3	306
Лааз	кг	81.8	-	-
Уут	кг	3.4	-	-
Шил	кг	▲ 442	510	425.9
Нийт дахин боловсруулсан	тн	▲ 1.56	1.05	0.87



Бид хамтран ажиллаж буй дахин боловсруулах үйлдвэрт картон цаас, хуванцар, лааз, шилийг 3 оффисоос цуглуулан хүлээлгэн өгч байна. Банкны үйл ажиллагаа тэлж байгаатай холбогдон хог хаягдлын хэмжээ жил ирэх бүр нэмэгдэж байгаа хэдий ч жил ирэх бүр нийт дахин боловсруулж буй хог хаягдлын хувь өссөөр байгаа юм.

Өмнөх онтой харьцуулахад **дахин боловсруулалт 48 хувиар өссөн** бөгөөд цаашид бид дахивар цуглуулж буй салбаруудын тоог нэмэн, оффис салбаруудын хог хаягдлын менежментийг сайжруулж байна. Үүнтэй холбогдуулан нийт ажилтнуудад зориулан хог хаягдал ангилан хаях, ухаалаг хэрэглээ, хог хаягдал дахин боловсруулахтай холбоотой сургалтыг дижитал хэлбэрээр оров.

АЖИЛТНУУДЫН ОРОЛЦОО

Ногоон элч хөтөлбөр



2024 онд банкны дотоод “Ногоон Элч” хөтөлбөр эхлүүлсэн ба 2024 оны байдлаар нийт 34 нэгжээс 50 ажилтнууд хамрагдан ногоон ажлын орчин бүрдүүлэх, мэдээ мэдээлэл хуваалцах гол зангилаа болон ажиллаж байна. Ногоон элч нар нь өөрсдийн салбар, нэгж дотроо хог хаягдлаа зөв ангилах, багасгах, эрчим хүч, усаа хэмнэх зэргийг уриалан манлайлж банкны үйл ажиллагаанаас үүдэх ус, хог хаягдал, эрчим хүчний хэрэглээг багасгахад хувь нэмрээ оруулсаар байна.

2024 онд нийт 20 ногоон элч сургагч багш нараар дамжуулан хот болон орон нутгийн нийт 79 салбар тооцооны төвийн 865 борлуулалтын ажилтнуудад тогтвортой санхүүжилтийн боломжуудыг тодорхойлох, чадавх бэхжүүлэх сургалт орсон байна.

Мэдлэг түгээх



2024 онд банкны дотоод сувгуудаар дамжуулан банкны ажилтнуудад тогтвортой хөгжил, байгаль орчин, эко амьдралын хэв маягт уриалсан мэдлэг мэдээллийг тасралтгүй түгээж байна. Үүний үндсэн дээр ажилтнууд ус, цахилгаанаа хэмнэх, хог хаягдлаа ангилан хаях, алхах зэрэг эко дадлуудыг хэрэгжүүлж эхлээд буй.



30
Anniversary
1995-2025
ГОЛОМТ БАНК

НИЙГЭМ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

2024 оны байдлаар дараах төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажилласан байна. Үүнд:

БОЛОМЖИЙГ БҮГДЭД ТӨСӨЛ

Голомт банк Монголын тусгай олимпын хороо болон Улаанбаатар Ротари клубтэй 2024 оноос хамтран ажиллаж эхэлсэн. Тус байгууллагуудын санаачилгаар зохион байгуулдаг "Боломжийг бүгдэд" төслийн ээлжит арга хэмжээг Өвөрхангай аймагт хэрэгжүүлэхэд Голомт банк дэмжин ажиллалаа. Хангай бүсийн

6 АЙМГИЙГ

хамарсан уг арга хэмжээнд оюуны хөгжлийн онцлогтой

230+

гаруй хүүхэд,



тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч оролцсон бөгөөд арга хэмжээний хүрээнд сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамруулав. Монголын тусгай олимпын хорооны "Боломжийг бүгдэд" төслийн онцлог нь спортоор дамжуулан оюуны хөгжлийн онцлогтой хүүхдүүдийн хөгжил, оролцоог дэмжих зорилготой. Иймд хүүхдүүдийн дунд спортын өдөрлөг зохион байгуулж, төслийн арга хэмжээний үр дүнг хүртэх хүүхэд, багачууд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдын цар хүрээг нэмэх боломжийг бий болголоо.

ӨВ СОЁЛЫН ГОЛОМТ



Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслүүдийг хэрэгжүүлэх, урт хугацаанд дэмжихээр "Өв соёлын голомт" төслийг санаачлан 2022 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллаж байна. Өмнө жилүүдэд:

**Түргэний балгас-Туулын Хар Түнэ орд,
Ингэт толгойн хүн чулуун хөшөө,
Эзэнт гүрний үеийн булш**

зэрэг томоохон дурсгалт газруудад археологийн малтлага, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Ингэт толгойн дурсгалт газрын судалгааг 2024 оны археологийн **ШИЛДЭГ СУДАЛГАА**-аар шалгарсан байна. 2024 онд Архангай аймагт:

"Хархул хааны балгас"

газарт археологийн малтлага судалгааны ажлыг эхлүүлээд байна.

ONESKY ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА



Эх орны ирээдүй болсон хүүхэд, багачуудынхаа эрүүл мэнд, боловсролд анхаарал хандуулж, хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг бөгөөд 2023 оноос хүүхдийн төлөөх сайн үйлсийн ажлуудаа өргөжүүлэн олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өрнүүлж, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт амьдардаг бага насны хүүхдүүдийн хөгжлийг дэмжихээр **"OneSky"** байгууллагатай хамтран ажиллаж байна. Тус төвөөр дамжуулан бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдээ ойлгон хүмүүжүүлэх, суралцах боломжуудыг нь нээхэд туслах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинжлэх ухаанд суурилан боловсруулсан хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, хэл яриа, сэтгэл хөдлөл, хоол тэжээл, орчны аюулгүй байдлын талаарх **"Гэр бүлийг чадавхжуулах"** цогц сургалт хөтөлбөрүүдэд хүүхдүүд, гэр бүл, эцэг эхчүүдийг үнэ төлбөргүй хамруулах юм.

“ЗҮРХ МАРТАХГҮЙ” ТӨСӨЛ



Голомт банкны дэргэдэх “Алтантүлхүүр” хүүхдийн сан “Зүрх мартахгүй” төслийг 2020 оноос хойш дэмжин ажиллаж байна. Төслийн багийнхан 2022 онд Монгол, Киргизстан, Тува гурван улсын олон мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулан, мэс засал хийж амьдрал бэлэглэсэн юм. Голомт банкны зүгээс тус төсөлд жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна шаардлагатай бусад зүйлсээр дэмжин ажилладаг бөгөөд хамтын ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар нийт

40 МЯНГАН ХҮҮХДИЙГ

үзлэг, оношилгоонд хамруулж,
1200+

гаруй хүүхдэд мэс заслыг амжилттай хийжээ.

Төслийн багийнхан анх жилд 44 хүүхдэд мэс засал хийх төлөвлөгөөтэй байсан ч хамтын ажиллагааны үр дүнд санхүүгийн болон бусад асуудлуудыг тодорхой хэмжээнд шийдсэнээр нэг жилд хийх мэс заслын тоог

350-360

болгон нэмэгдүүлээд байна.

МОРИН ХУУРЫН ЧУУЛГА



Голомт банкны хамт олон үндэсний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор эх орны онцгой өв соёлын гол төлөөлөл болох Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны түнш, ерөнхий ивээн тэтгэгчээр **14 дэх жилдээ** хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд Морин хуурын чуулгын зүгээс дотооддоо төдийгүй дэлхийн тайзнаа нэр хүндээ бататгаж, олон мянган хүний талархлыг хүлээсэн, чанартай уран бүтээлүүдийг эрхлэн гаргаснаас **“Playing Love”** болон **“Novel Melody”** зэрэг бүтээлүүд нь олон улсад танигдаад байна. Хоёр байгууллагын хамтын ажиллагааны хугацаанд гадаад болон дотооддоо үндэсний урлагийг сурталчлан таниулж, нийт **40 орчим** томоохон тоглолт хийгээд байна.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР



“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Монгол Улсын хэмжээнд 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ойн санг 9%-д хүргэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэхээр Голомт банк хамтран ажилладаг. 2024 онд “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан”-г банк хоорондын төлбөр тооцооны үйл ажиллагаагаар дэмжин

1.2 ТЭРБУМ

төгрөгийг санд төвлөрүүлж, 2024 оны ШИЛДЭГ ДЭМЖИГЧ байгууллагаар шалгарав.

“АЛТАНТҮЛХҮҮР” ХҮҮХДИЙН САН

Төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдийг эх орондоо оношлон, мэс засал хийж, амь насыг нь аврах зорилготой уг төслийг Голомт банк эхэлсэн цагаас нь дэмжиж, санхүүгийн болон шаардлагатай бусад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж буй билээ. Цаашид нийгмийн хариуцлагын хүрээнд “One Sky” хүүхдийн төлөөх ОУ-ын байгууллагатай хамтран хүүхэд хөгжлийн тоглоомын төвийг байгуулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллахаар боллоо.



МИК

Орон сууцны ипотекийн зээлийг нэн тэргүүнд зорилтот харилцагчид нь хүргэх, нээлттэй шударга тогтолцоог бүрдүүлэхийг зорилгоо болгож, зохицуулагч байгууллагуудтай хамтран удирдлагаар ханган

262 ТЭРБУМ

төгрөгийн эх үүсвэрээр 2,232 иргэнд 6%-ийн хүүтэй ипотекийн зээл олгож, орон сууцжуулав.

АЯН УРАМШУУЛАЛ



ГОЛОМТЫН ТӨГӨЛ

Голомтын төгөлд 5 дахь жилдээ 200 гаруй гацуур мод тарьж нийтдээ

1030 МОДТОЙ

боллоо.

ЦУСАА ХАНДИВЛАЯ

Голомт банкны ажилтнууд 2019 оноос жил бүр цусаа хандивладаг уламжлалтай ба 2024 оны хувьд 120 гаруй ажилтан цусаа хандивлаж

360 ГАРУЙ ХҮНИЙ

амь аварлаа.



ХАЙРАА ХУВААЛЦЪЯ

Бид жил бүр "Хүүхдийн баяр", "Шинэ жилийн баяр"-аар зорилтот бүлгийн хүүхдүүдэд зориулан "Хайраа хуваалцъя" аянг зохион байгуулдаг билээ. 2024 онд нийт салбар нэгжүүдээс цугларсан хувцас хэрэгсэл болон мөнгөн хандивыг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн нийт

6 АСРАМЖИЙН ТӨВ

дэх зорилтот бүлгийн хүүхдүүдэд гардуулан өглөө.

ОЮУТНУУДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



Улс эх орны тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, боловсролыг дэмжих, оюутан залууст санхүүгийн болон тэдний хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд бизнесийн салбараас анхлан "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр"-ийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд

**Монгол Улсын
50+**

гаруй их, дээд сургуулийн мэргэжлийн чиглэл
харгалзахгүй

1,800+

гаруй оюутанд сургалтын тэтгэлэг олгосон байна.

2024 онд "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр"-т Монгол Улсын их, дээд сургуулиудын 3, 4-р дамжааны 1,500 гаруй оюутан материалаа ирүүлснээс шилдэг оюутнуудаа шалгарууллаа. Тэтгэлэгт хөтөлбөрийн 20 дахь жилийн ойн босгон дээр тэтгэлгийн хэмжээг 2,000,000 төгрөг болгон нэмэгдүүлж, тэтгэлэгт оюутан Голомт банканд урилгаар бүтэн болон хагас цагаар шууд ажиллаж эхлэх боломжтой болсон.

Энэхүү хөтөлбөрийн тэтгэлэгт оюутан болсноор Голомт академийн хувийн хөгжлийн болон мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдаж, суралцах хугацаандаа мэргэжлийн ментор, коучингийн удирдлагатай хамтран ажиллах зэрэг олон боломжийг хүртэж байна.

"Оюутны тэтгэлэгт хөтөлбөр" нь үндэсний хэмжээний, нэр хүндтэй хөтөлбөр бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилд нийт 200 сая төгрөгийн тэтгэлгийг ийнхүү 100 оюутанд олгосноор тэтгэлгийн үр шимийг хүртсэн

1,900+ гаруйд,

шилдэг оюутны тоо

1.3тэрбум

тэтгэлгийн хэмжээ



ХҮНИЙ НӨӨЦ - ҮЛ ЯЛГАВАРЛАХ, ТЭГШ ЭРХ, ОРОЛЦОО

Голомт банк ажилтны замналыг тасралтгүй сайжруулах, ажилтан бүрд ээлтэй, сурч хөгжих, өөрийгөө сорих боломжоор дүүрэн тогтолцоог бий болгох замаар банкны урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.


НИЙТ АЖИЛТНЫ ТОО 2756	ШИНЭ АЖИЛТАН 880 гаруй 33% шинэ төгсөгч	НИЙТ АЖИЛТНЫ 71% 35-с доош насныхан	АЖИЛТНУУДЫН 28% Career path index
АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА Эр: 30% Эм: 70%	УДИРДЛАГЫН БАГ Эр: 58% Эм: 42%	GPTW 89%	АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ИНДЕКС 91%
АЖИЛТНЫ УР ЧАДВАРЫН ИНДЕКС 92%	АЖИЛТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ 91%	ТОГТВОРТОЙ АЖИЛЛАСАН ЖИЛ 5.4 жил	НЭГ АЖИЛТАНД НОГДОХ СУРГАЛТ 6 өдөр



“Итгэлцэл дээр суурилсан, өндөр гүйцэтгэлтэй байгууллагын соёл”-ыг бий болгох зорилгоор судалгаа хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг тусгай эрх бүхий олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага болох “Great place to work institute”-ээс “Ажиллахад хамгийн таатай газар” батламжийг Голомт банк байгууллагын дотоод соёлоороо тэргүүлэн гурав дахь жилдээ авлаа.

ГОЛОМТ БАНК БОНЗ-ЫН ХҮРЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ НЬ

Голомт банк нь НҮББОХ-ын хариуцлагатай банкны зарчмуудын хүрээнд 2024 оны 10-р сард албан ёсоор батлагдсан 2030 он хүртэлх шинэчилсэн хамрах хүрээг хэрэгжүүлэх үүргийг хүлээн, дагаж мөрдөхөөр ажиллаж байна¹⁰. Үүнд:



Парисын хэлэлцээр болон ТХ313-ын хүрээнд “net zero” буюу уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засгийн хөгжлийг цогцлоох



НҮБ-ын “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын тулд ТХЗ 1,5,8,10-ын хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх



Kunming-Montreal Global Biodiversity Framework болон ТХЗ 14,15-ын хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалах



НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын хүрээнд хүний эрхийг хамгаалах

¹⁰Эх сурвалж: https://www.unepfi.org/wordpress/wp-content/uploads/2024/10/PRB_Leading-the-Way-to-a-Sustainable-Future.pdf

ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН ДЭЭДЛЭХ



Голомт банк шударга бизнес, хүний эрх, ёс зүй, байгаль орчин, хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хүний эрхийг хамгаалж, хүндэтгэхийг нийт ажилтнуудад уриалан, хандлагыг өөрчлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсээр ирсэн. Иймээс НҮББОХ-ийн хариуцлагатай банкны зарчмуудыг хэрэгжүүлдгийн хүрээнд Хүний эрхийн тухай заалтыг илүү нарийвчлан шинэчилж Тогтвортой Хөгжлийн бодлогодоо тусгалаа.

Хүний эрхийн бодлого



Банк нь дотоод үйл ажиллагаа болон бизнесийн бүхий л үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэн, НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд болон бусад олон улсын болон үндэсний хүний эрх, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой стандарт, зарчмуудыг мөрдөн ажиллахаа Тогтвортой хөгжлийн бодлогодоо тусган амлалт өгөөд байна. Тогтвортой хөгжлийн бодлогыг 2024 оны сүүлийн хагаст шинэчлэн сайжруулахдаа хүний эрхтэй холбоотой заалтуудыг тусган баяжуулав.

Хүний эрхийн магадлан шинжилгээ



Цаашид хүний эрхийн магадлан шинжилгээг хийх, сөрөг нөлөөллийг илрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган, төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизм



Банк нь дотооддоо хүний эрхтэй холбоотой зөрчил мэдүүлэх, зүй бус үйл явдлыг мэдээлэх хэд хэдэн сувгуудыг хэрэгжүүлдэг ба мэдээлэл, мэдээлэгчийн нууцлал бүрэн хамгаалагдсан байдаг. Үүний хүрээнд шүгэл үлээх зааврыг дижитал хэлбэрт шилжүүлэн, ажилтнуудад нээлттэй байршуулав.

АЖИЛТНУУДЫН ХАНГАМЖ



Сургалт хөгжил

Голомт академи-аар дамжуулан дотоодын сургагч багш нар 150 гаруй цахим сургалт, контентыг бэлтгэж давхардсан тоогоор 82,000 удаагийн хандалтаар ажилтнууд сургалтад хамрагдаад байна.



Банкны эмч

Урьдчилсан сэргийлэх болон эмчийн анхан шатны үзлэг, үйлчилгээ, эрүүл мэндийн аян, цус хандивлах аян, бариа засал, нэмэлт эрүүл мэндийн даатгал гэх мэт олон төрлийн эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүллээ



Спорт арга хэмжээ

Голомт банкны адал явдалт спорт, явган аялал" нийт 9 чиглэлд амжилттай зохион байгуулж давтагдсан тоогоор нийт 1,000 гаруй ажилтан хамрагдсан.

"Голомт банкны спорт наадам"-ыг хавар, намар зохион байгуулдаг ба жил бүр 1,100 орчим ажилтнууд хамрагддаг.



Тэтгэврийн ууган сан

Бид ажилтнууддаа "Тэтгэврийн ууган сан"-аар дамжуулан урт хугацааны хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлэн ажилладаг



Сонирхлын клубууд

Сонирхлын клубуудад нэгдэх, үүсгэн байгуулах, спорт соёлын арга хэмжээ, хичээлүүдэд хамрагдах боломжууд нээлттэй



Цалинтай чөлөө

Ажилтны өөрийн болон хүүхдүүдийн төрсөн өдрийн цалинтай чөлөөг олгодог



Ахмад, жирэмсэн ажилтнууд

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэх, жирэмсэн ажилтнуудын ажлын цагийг богиносгох



Ойн булаг зуслан

Зуны улиралд ажилтнууддаа цэвэр агаарт гэр бүлээрээ гарч, амрах "Ойн булаг зуслан"-г хэрэгжүүлдэг.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

Санхүүгийн хүртээмж

Голомт банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг нийгмийн бүх бүлэгт цаг алдалгүй, хүртээмжтэй авах боломжийг олгох нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг хэрэгжүүлэх гол хөшүүрэг гэж үздэг. Бид нийгмийн илүү олон бүлэгт хэрэгцээ шаардлагад нь нийцсэн, хариуцлагатай, тогтвортой байдлаар ашиг тустай, хүртээмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авах боломжоор хангахыг зорин ажиллаж байна.

Дижитал шилжилт

Дижитал шилжилт нь банкны хувьд үйл ажиллагааны болон гүйлгээний зардлыг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбар болон хүртээмж багатай бүлгүүд болох эмэгтэйчүүд, хүүхдүүд, малчид, алслагдсан бүс нутагт оршин суугаа иргэд, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэрэгцээг хангах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгож байдаг. Ухаалаг утсыг ашиглан цахим үйлчилгээ авах боломжгүй иргэд салбар тооцооны төвүүд болон киоскуудаар дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэсээр байна.

Дижитал шилжилт	2024 /өөрчлөлт %/	2023 /өөрчлөлт %/
Дижитал сувгууд хэрэглэгчдийн тоо	+12.6%	+16.4%
Дижитал сувгууд идэвхтэй хэрэглэгчдийн тоо	+11.3%	+17.1%
Дижитал сувгуудаар хийсэн гүйлгээний тоо	+21.7%	+38.6%
Social Pay хэрэглэгчдийн тоо	+35.1%	+37.2%
Social Pay-ээр хийсэн гүйлгээний тоо	+65.5%	+121.4%

ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ



Голомт банк Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур болсон жижиг, дунд бизнесүүдээ дэмжин ажилласаар ирсэн. Тэр дундаа бизнес эрхлэгчдийн 37 хувийг, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 68 хувийг эзэлдэг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээ санхүүгийн хувьд дэмжин тэдэнд тохирсон бизнесийн орчин, бодит дэмжлэгийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээгээ тасралтгүй хүргэж байна.

ЖДБ ЭРХЛЭГЧДЭД
ОЛГОСОН ЗЭЭЛ
30% өсөв

БИЗНЕС ЭРХЛЭГЧ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ
ЗЭЭЛ
9 дахин өсөв

МЕНТОРШИП ХӨТӨЛБӨРТ
ХАМРАГДСАН ААН ТОО
10 дахин нэмэгдсэн

WOMEN OWNED ТОХИРЛЫН ТЭМДЭГ

50
байгууллагад олгов

13
байгууллага шошгондоо
байршуулсан

Албан ёсны цахим хуудас
www.womenowned.mn
нээгдэв





ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО

МЭДЛЭГЭЭ ХУВААЛЦАХ, БУСДЫГАА МАНЛАЙЛАХ НЬ



Улаанбаатарын яриа хэлэлцээ 2024 2024 оны 6-р сарын 6-7

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын IX бага хуралд Голомт банк ивээн тэтгэгчээр дэмжин оролцов. Тус хуралд “Зүүн хойд Ази дахь уур амьсгалын өөрчлөлт, аюулгүй байдлын сорилтууд” сэдвийн хүрээнд 30 гаруй улс, олон улсын байгууллага, дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачид хэлэлцүүлгүүд өрнүүлсэн юм.



FMC & Business Conference 2024 2024 оны 10-р сарын 7-8

Голомт банкнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Financial Managers Convention болон Business Conference арга хэмжээнүүдэд тогтвортой санхүүжилтийн сэдвийг онцлон “Тогтвортой усны болон хог хаягдлын менежмент”, “МУ-ын ногоон барилгын стандарт” зэрэг сэдвүүдээр салбарын төлөөлөгчдийг урьж оролцуулан, салбар хуралдаануудаар дамжуулан харилцагч нарт ногоон эдийн засгийн шилжилтийг цогцлоох цаг үеийн мэдээллийг хүргэв. Мөн тус арга хэмжээний үеэр тогтвортой санхүүжилтийн булангаар дамжуулан Голомт банкны ногоон зээлийн бүтээгдэхүүний танилцуулга, ногоон санхүүжилтийн сайн туршлагууд, бизнесээ ногоон болгох боломжуудын талаар мэдээллийг оролцогч нарт түгээв.



Тогтвортой Санхүүжилтийн Форум 2024 оны 11-р сарын 27-29

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Монголын Тогтвортой Санхүүгийн Форум нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Ивээл Дор "Монгол улс-Ногоон хөгжлийг санхүүжүүлэх нь" сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицохоос эхлээд нийгмийн оролцоо, биологийн олон янз байдлыг хамгаалах, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны санхүүжилт зэрэг нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх санхүүгийн шинэлэг шийдлүүдийг хэлэлцсэн.

Энэ жилийн арга хэмжээнд Голомт банкнаас дотоодын дэмжигч байгууллагаар хамтран, Голомт банкны удирдлагууд тогтвортой санхүүжилт, нөлөөллийн хөрөнгө оруулалтын боломжууд, хөрөнгө оруулагчдын шаардлагын талаар өөрсдийн туршлагаа хуваалцан оролцов.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Банк санхүүгийн байгууллагын хувьд өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад оруулах хувь нэмэр өндөр салбарын нэг билээ. Иймээс БОНЗ-ын хүрээнд оролцогч талуудын хүлээлтийг хангах чухал үүргийг хүлээгээд байна.

	Хөрөнгө оруулагчид	Харилцагчид	Ажилтнууд	Нийгэм	Зохицуулагч байгууллагууд
	Бид БОНЗ-ын тайлагналыг ил тод нээлттэй байдлаар тайлагнаж байна	Бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэхээр ажиллаж байна	Бид чадварлаг хамт олон бүрдүүлэх зорилгоор ажилтнуудаа хөгжүүлэн ажиллаж байна	Бид нийгэмд тулгамдаад буй санхүүгийн асуудлууд, хүртээмжтэй байдлыг бий болгоход онцгойлон анхаарч ажиллаж байна	Бид хууль, дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна
Бид хэрхэн хамтын ажиллагааг өрнүүлж байна вэ?	Тогтвортой Хөгжлийн Тайлан /жил бүр/	Салбар, дижитал сувгууд болон харилцагчийн үйлчилгээний	Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа /жил бүр/	АмЧам, АустЧам, Монголын Бизнесийн зөвлөл, Худалдаа	Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж байна
	НҮББОХ-Банк Санхүүгийн Санаачилга, хариуцлагатай Банкны Зарчмуудын хэрэгжилтийн тайлан /жил бүр/	утас гэх мэт олон сувагт харилцаа Харилцаааны болон Корпорейт менежерүүд	Ажиллахад таатай байгууллага батламж /жил бүр/ Удирдах ажилтнуудад зориулсан арга хэмжээ /жил бүр/	Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн байгууллага ба үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцдог	Эдийн засаг хөгжлийн яамтай хамтран ажиллаж байна
	Санхүүгийн тайлангууд / улирал бүр, жил бүр/	Харилцагчдын сэтгэл ханамжийн судалгаа /жил бүр/		НҮБ болон холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж байна	

ГИШҮҮНЧЛЭЛ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Голомт банк нь хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй БОНЗ-ын олон улсын стандарт, шаардлагуудтай нийцсэн байх, сайн туршлагуудаа оролцогч талуудтай хуваалцах үүднээс олон талт хамтын ажиллагааг өргөжүүлсээр байна.



Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо /MSFA

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ToC) нь гишүүн санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой байдал, ногоон хөгжлийг дэмжих замаар санхүүжилтийн тогтолцоог ногоон болгох зорилготой ГҮТББ юм. Тус холбоо нь Тогтвортой хөгжлийн зорилтууд, Парисын хэлэлцээр, мөн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр, Ногоон хөгжлийн бодлого зэрэгт нийцүүлэн эерэг нөлөөллийг бий болгох нэгдсэн, болон хувьсах бодлого боловсруулах, бизнесийн арга барил, олон салбарын санаачилгыг боловсруулахад гишүүд, түншүүдтэйгээ нягт хамтран ажилладаг.

Голомт банк нь Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн зөвлөл болон тайлагналын зөвлөлд тус тус идэвхтэй хувь нэмэрээ оруулж байна.



PRINCIPLES FOR
RESPONSIBLE
BANKING

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр-Санхүүгийн санаачилга, Хариуцлагатай банкны зарчмууд / UNEP-FI, PRB

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Санхүүгийн санаачилга нь НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчмуудаар дамжуулан олон улсын банкуудтай хамтран ажиллаж эерэг, ногоон шилжилтийг хурдасгах зорилготой юм. Олон улсын банкны салбарын талаас илүү хувийг төлөөлж буй 330 гаруй банк гишүүнээр элссэн байдаг бөгөөд тус банкууд нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд болон Парисын гэрээ зэрэг олон улсын гэрээ хэлэлцээртэй үндсэн стратеги, шийдвэр гаргах, зээл олгох, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа уялдуулдаг.

Голомт банк нь тус санаачилгыг үүсгэн байгуулагч гишүүний нэг бөгөөд Монгол Улсыг төлөөлөн дангаараа ажилладаг.



Нүүрстөрөгчийн Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл /Partnership for Carbon Accounting Financials (PCAF)

PCAF нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудыг санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох, ил тод нээлттэй болгох нэгдсэн аргачлалаар ханган ажилладаг юм.

Голомт банк нь 2023 оны 2-р сард PCAF-ийн гишүүнээр элссэн бөгөөд PCAF аргачлалыг ашиглан нийт зээлийн багцын хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоод байна.



Шинжлэх ухаанд суурилсан зорилтуудыг тодорхойлох санаачилга /Science Based Targets initiative (SBTi)

SBTi нь Нүүрстөрөгчийн ил тод байдлын төсөл (CDP), НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, Дэлхийн нөөцийн хүрээлэн (WRI), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) хоорондын хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, цаашлаад тэг ялгаруулалтад хүргэх олон улсын шилдэг туршлагыг тодорхойлж, сурталчлах зорилготой хамтын санаачилга бөгөөд байгууллагуудад хөндлөнгийн хяналт үнэлгээг хийх үйлчилгээг үзүүлдэг билээ.

Голомт банк SBTi санаачилгын дагуу уур амьсгалын шинжлэх ухаанд нийцүүлэн дунд болон урт хугацааны зорилтуудаа гарган, Үндэсний зорилтод хувь нэмэртэй нийцүүлэн тодорхойлсон болно.



Joint Impact Model Foundation

Голомт Банк Нидерландын нөлөө бүхий FMO банкнаас эхлэлтэй "Joint Impact Model Foundation" байгууллагад 2024 оны 3-р сарын 15-ны өдөр албан ёсны гишүүнээр элсэв.

Joint Impact Model Foundation-д гишүүн болсноор Голомт банк олгож буй санхүүжилтээр дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хий, шинээр бий болгож буй ажлын байрны тоо болон эдийн засгийн өсөлтөд хэрхэн хувь нэмрээ оруулж байгаа зэргийг олон улсын аргачлалын дагуу тооцоолон, бодит нөлөөллийг хэмжиж, нээлттэй ил тод тайлагнах боломжтой болсон байна.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ЗАСАГЛАЛ

Голомт Банкны төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), удирдлагын баг, бусад холбогдох хороо нь тогтвортой байдлын эрсдэл ба боломжуудыг хянах, удирдах ажлыг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэхээр зорин ажиллаж байна.

• ТУЗ-ын түвшинд

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Банкны урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, стратегийг хариуцах бөгөөд хороод нь стратегийн шийдвэрийг хянаж, удирдан чиглүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжуудыг хянах, удирдах тогтолцоог бий болгох заалтуудыг хороодын чиг үүрэгт оруулахаар ажиллаж байна. Стратегийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлүүдийг хянах, удирдах; Парисын хэлэлцээрийн дагуу банкны үйл ажиллагаа, тэр дундаа харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг бууруулахад оршино.

• Удирдлагын багийн түвшинд

Удирдлагын багийн гишүүн бүр өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд стратегийн болон бизнесийн шийдвэрийг 2050 он хүртэлх БОНЗ-ын зорилго зорилтод нийцүүлэн гаргах үүрэгтэй. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг тодорхойлох, хянах, удирдах чиг үүргийг "хоёрдугаар шугам"-д хамаарах Эрсдэлийн удирдлагын газар (100 хувийн үүрэгтэй), Олон улсын банкны газрын Тогтвортой санхүүжилтийн хэлтэс (20 хувийн үүрэгтэй), Зээлийн газар (хэлтсийн чиг үүргээс хамааран 60-100 хувийн үүрэгтэй) болон Санхүү удирдлагын газар (100 хувийн үүрэгтэй) хамтран хариуцаж "Нэгдүгээр шугам"-д хамаарах нэгжүүдийн чиг үүргийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчин нийгэм засаглал (БОНЗ)-ын эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүргийг хүлээн хамтран ажиллаж байна.

• Дэмжих засаглал

Уур амьсгалын өөрчлөлтийн болон байгаль орчин нийгэм засаглал (БОНЗ)-ын бодлогын хэрэгжилтийг хангахад чиглүүлэх, хянах, удирдах тусгайлсан Тогтвортой хөгжлийн хороо, Жендэрийн тэгш байдлын хороо болон Тогтвортой хөгжил, санхүүжилт хариуцсан нэгж ажиллаж байна.

2024 онд Голомт банк нь олон улсын мэргэжлийн байгууллагаас СТОУС S1 болон S2 тайлагналын стандартыг хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах ажлыг хийсэн ба 2027 он хүртэл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган ажилласан байна. Энэхүү ажлын хүрээнд 2024 онд Голомт банк нь Тогтвортой хөгжлийн бодлогоо шинэчилж дараах заалтыг Дотоод үйл ажиллагаандаа баримтлах байгаль орчин, нийгмийн зарчим хэсэгт оруулсан болно. Үүнд:

"2.9.6 Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоонд тогтвортой байдал болон уур амьсгалын эрсдэлийг нэгтгэнэ. Банк нь тогтвортой байдал, уур амьсгалтай холбоотой эрсдэлийг уламжлалт санхүүгийн эрсдэлийн бүр ангилалтай эн тэнцүү хэмжээнд тодорхойлж, үнэлж, удирдана. Үүнд зээл, зах зээл, үйл ажиллагаа, нэр хүнд, хөрвөх чадвар, бизнесийн загвар, төвлөрөл зэрэг эрсдэлүүд багтана."

Банк нь Тогтвортой хөгжлийн бодлогод орсон уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлтэй холбоотой шинэ заалтын хэрэгжилтийг хангах ажлуудыг үе шаттайгаар хийн ажиллах байна.

БАНКНЫ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХҮРЭЭН ДЭХ ЗАСАГЛАЛ

Голомт банк нь корпорейт, ЖДҮ, иргэдэд зориулсан бүтээгдэхүүн хөгжлийн нэгжүүдтэй ба Тогтвортой санхүүжилтийн хэлтэс нь Монгол улсын Таксономиуд болон өөрийн Тогтвортой санхүүжилтийн хамрах хүрээ баримт бичигтэй нийцүүлэн бүтээгдэхүүний шаардлага болон баталгаажуулалтыг тодорхойлох замаар ногоон угаалт-аас урьдчилан сэргийлж байна¹¹.

Тогтвортой санхүүжилтийн хэлтэс нь банкны тогтвортой, ногоон багцын ногоон угаалтын эрсдэлийг бууруулах мөн ногоон болон нийгмийн санхүүжилтэд хамрагдах боломжтой санхүүжилт, шалгуур, баталгаажуулах баримт бичгүүдийг олон улсын эрх зүйн удирдамж, стандартаас гадна Монгол Улсын Ногоон Таксономи, Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын хорооноос баталсан Монгол Улсын ТХЗ¹² -ын санхүүжилтийн Таксономийн дагуу тодорхойлдог.

Банкны Тогтвортой санхүүжилтийн хамрах хүрээ баримт бичиг нь холбогдох бүтээгдэхүүний шалгуур шаардлагыг тодорхойлох, санхүүжилтийн зориулалтыг ил тод нээлттэй болгох, нөлөөллийг хэмжих удирдамжаар хангадаг. Энэхүү баримт бичиг нь S&P Global-аас хөндлөнгийн баталгаажуулалт авсан ба банкны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг найдвартай, үр дүнтэй бөгөөд олон улсын стандарт, удирдамжуудтай нийцэж байгааг баталж байгаа билээ.

УРАМШУУЛЛЫН БҮТЭЦ

Голомт банкны тогтвортой хөгжилтэй холбоотой зорилго, зорилтууд нь ажилтнуудын үнэлгээ болон урамшууллын тогтолцоонд тусгагдсан бөгөөд Санхүүгийн удирдлагын газрын дэргэдэх Төлөвлөлт, үнэлгээний хэлтэс хяналт тавин ажиллаж байна.

• Хагас жилийн урамшуулал

Урамшуулал нь байгууллагын банк, Жижиг дунд банк болон иргэдийн банкны газруудын тогтвортой, ногоон багц бүрдүүлэх зорилттой уялдан тавигдсан билээ.

¹¹Ногоон Угаалт буюу тогтвортой хөгжлийн зорилтод хамрагдах мөнгө угаах, залилан зэрэг гэмт хэрэг болно.

¹²ТХЗ – Тогтвортой Хөгжлийн Зорилт

2024 КРІ ЖИН

Гүйцэтгэлийн хэмжүүр	Жин	Босго
Уур амьсгал	2.5%-6%	Тогтвортой хөгжил болон санхүүжилтийн хүрээнд тавьсан зорилго, зорилтоо хэрэгжүүлэх • Нийт багцын 10%-ийг тогтвортой, ногоон болгох зорилт • Санхүүжилтээ Парисын хэлэлцээр, НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай (ТХЗ) уялдуулах банкны зорилт

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ БА БОЛОМЖУУД

БИЕТ ЭРСДЭЛ

Биет эрсдэлүүд нь цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй бөгөөд үер, "зуд" зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэх үйл явдлаас үүдэлтэй байж болно.

ШИЛЖИЛТИЙН ЭРСДЭЛ

Шилжилтийн эрсдэл нь нүүрсхүчлийн хий бага эдийн засагт шилжихээс үүдэлтэй. Энэ нь цаг уурын өөрчлөлт, түүнтэй холбоотой нөлөөлөлд дасан зохицохын тулд бодлого, зохицуулалт, хууль эрх зүйн чухал өөрчлөлт, түүнчлэн технологи, зах зээлийн хувьсал зэрэгт захирагдах асуудал юм.

ЦАГИЙН ХЯЗГААР

Биет болон шилжилтийн эрсдэлийн нөлөөлөл нь мэдэгдэхүйц бөгөөд өргөн цар хүрээтэйгээр Голомт банкны багц болон богино, дунд, урт хугацаанд санхүүгийн гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлтэй.

Богино хугацаанд цаг агаарын эрс тэс үзэгдлүүд болон цаг уурын нөлөөллөөс үүдэлтэй биет эрсдэл Голомт банкны биет хөрөнгө, дэд бүтцэд шууд аюул учруулах эрсдэлтэй. Түүнчлэн шууд алдагдалд хүргэж, засварын зардал болон даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй юм. Үүний нэгэн адил цочмог буюу байгалийн гамшгууд Голомт банкны үйлчлүүлэгчдийн хөрөнгийг эрсдэлд оруулах, бизнесийн үйл ажиллагааг тасалдуулж болзошгүй бөгөөд харилцагчдын хөрөнгийн үнэ цэнд сөргөөр нөлөөлж, ашгийг бууруулах, улмаар Голомт банкны чанаргүй зээл ихсэхэд хүргэж болзошгүй. Нэмж дурдахад, биет эрсдэлийн магадлал өндөр бүс нутагт үйл ажиллагаа явуулахад даатгалын шимтгэл өндөр эсхүл даатгалын хамрах хүрээ хязгаарлагдмал байж болох нь өөрөө эрсдэл болох боломжтой.

Шилжилтийн эрсдэл бүх цаг хугацаанд тохиолдох боловч дунд хугацаанд илүү өргөн тохиолдох төлөвтэй байдаг. Илүү байгальд ээлтэй, ногоон технологи нэвтрүүлэх, бизнесийн тогтвортой загварт шилжих зардал нь бизнесийн санхүүгийн эх үүсвэрийг шавхагдуулах, ашиг орлого, урт хугацааны оршин тогтнох чадварт нөлөөлдөг. Мөн Голомт банк зэрэг санхүүгийн байгууллагууд ногоон, тогтвортой эдийн засагт шилжихэд чиглэсэн шинэ бодлого, хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөхийн тулд зарцуулах зардал нэмэгдэх, бусад нөөцийн хомсдол учруулж болзошгүй юм.



Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн шилжилтийн эрсдэлүүд нь Голомт банкны хөрөнгийн үнэ цэнийг бууруулж ашиг орлогыг бууруулах магадлалтай ба ялангуяа нүүрстөрөгчийн хий ихээр ялгаруулах салбаруудад үйл ажиллагаа явуулж буй харилцагчдад хамаарах хөрөнгийн үнэ цэнд нэн тэргүүнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудалд дасан зохицохдоо удаан эсхүл хариу үйлдэл үзүүлэхгүй байгаа аж ахуйн нэгжүүд нэр хүндийн эсхүл хуулийн хариуцлага хүлээх эрсдэлтэй ба энэ нь банкны хувьд үйлчлүүлэгчид болон гадаад, дотоод хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах эрсдэл бий болгох боломжтой. Голомт банкны явуулж буй үйл ажиллагааны хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээлэл цацагдах, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой маргаанд орооцолдох эрсдэл нэмэгдэх боломжтой. Түүнчлэн Голомт банкны бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ, ашигт ажиллагаа, хөрөнгийн үнэ цэн, үнэт цаасны зах зээлийн арилжааны нөхцөл зэрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Урт хугацаанд дэлхийн дулаарал, температурын өсөлтөөс үүдэлтэй нөлөө нь экосистем болон нийгмийн бүтцэд нөлөөлөх хандлагатай байдаг. Дэлхий даяар болон Монгол Улсад ажиглагдахуйц өөрчлөлтүүд хэдийн бий болж эхэлсэн. Монгол улсын хувьд зарим эрсдэлүүд төлөвлөж байснаас богино хугацаанд үүсэх магадлалтай байгаа ба ил тод нээлттэй өгөгдөл улсын хэмжээнд олоход хэцүү тул уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлүүд хэдий хугацаанд, хэр давтамжтайгаар, ямар цар хүрээтэй нөлөө үзүүлэхийг таамаглахад бэрхшээлтэй байна.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ НЬ ЭРСДЭЛИЙН ХӨДӨЛГӨХ ХҮЧ

